



The Asia Foundation



АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН
ОЙЛГОЛТ МЭДЛЭГ ТОГТООХ СУДАЛГАА

2016



Canada 



The Asia Foundation



Sant-Maral Foundation

Энэхүү судалгааг Канадын Засгийн газар, Канадын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр хийсэн болно. Судалгааг Азийн Сан, Сант Марал сантай хамтран явуулсан бөгөөд судалгааны үр дүн нь Канадын Засгийн газар болон Канадын Гадаад хэргийн яамны үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГ ТОГТООХ СУДАЛГАА

МОНГОЛ УЛСАД АРДЧИЛСАН ОРОЛЦООТОЙГООР ТӨРИЙН АЛБАНД
САЙН ЗАСАГЛАЛ, ИЛ ТОД БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ

2016 он

2016

АГУУЛГА

Оршил	8
Судалгааны арга зүй	9
Судалгааны гол үр дүн	11
1. Тулгамдсан асуудлууд	14
2. Сонгуулийн ил тод, шударга байдал	20
3. Авлигын түвшин	28
4. Авлигын чиг хандлагын үнэлгээ	36
5. Авлигатай тэмцэх	42
6. Авлигатай тэмцэх санаачилгууд	54
7. Шударга хандлага	58
8. Дээд түвшний авлига	64
9. Өрхийн түвшний авлига	74
Судалгаанд ашигласан асуулга	79

ЗҮРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1	2016 он Түлгамдсан асуудлууд	14
Зураг 1.2	2015 он Түлгамдсан асуудлууд	14
Зураг 1.3	Ажилгүйдэл	15
Зураг 1.4	Авлига	15
Зураг 1.5	"Ажилгүйдэл" болон "Авлига"-ыг насны бүлгээр харьцуулсан байдал	16
Зураг 1.6	"Ажилгүйдэл" болон "Авлига"-ыг боловсролын түвшнээр харьцуулсан байдал	16
Зураг 1.7	Ажилгүйдэл" болон "Авлига"-ыг судалгаанд оролцогчдын оршин суугаа газраар харьцуулсан байдал	17
Зураг 1.8	"Ажилгүйдэл" болон "Авлига"-ыг судалгаанд оролцогчдын хүйсээр харьцуулсан байдал	17
Зураг 1.9	"Авлига манай улсад тогтсон заншил болсон"	18
Зураг 2.1	Сонгуультай холбоотой дараах үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? Бэлтгэлийн үе шат	20
Зураг 2.2	Сонгуультай холбоотой үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? Кампанит ажлын санхүүжилт	21
Зураг 2.3	Сонгуультай холбоотой үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? Сонгуулийн сурталчилгаа	22
Зураг 2.4	Сонгуультай холбоотой үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? Санал тоолох	23
Зураг 2.5	Сонгуультай холбоотой үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? Сонгуулийн дүнг нэгтгэх	24
Зураг 2.6	Дундаж үзүүлэлтийн харьцуулалт	24
Зураг 2.7	Сонгуулийн шинэ хуулийн ач холбогдол болон үр нөлөө	25
Зураг 3.1	Авлигын үр нөлөө	28
Зураг 3.2	Авлигын тархалт, 2016	29
Зураг 3.3	Авлигын тархалт, 2015	29
Зураг 3.4	2016 оны авлигын үнэлгээ, салбараар	30

Зураг 3.5	2016 оны авлигын зэрэглэл, хүйсээр	32
Зураг 3.6	Авлигад автсан байгууллагуудын зэрэглэл - судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн салбараар	33
Зураг 4.1	Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?	36
Зураг 4.2	Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ?	37
Зураг 4.3	Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? (Хүйсээр)	37
Зураг 4.4	Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ? (Хүйсээр)	38
Зураг 4.5	Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? (Ажил эрхлэлтийн салбараар)	38
Зураг 4.6	Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ? (Ажил эрхлэлтийн салбараар)	39
Зураг 4.7	Хүн амын тархалт ажил эрхлэлтийн салбараар	39
Зураг 5.1	Авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ?	42
Зураг 5.2	Авлигатай тэмцэх үр дүнтэй арга замууд	43
Зураг 5.3	Авлигатай тэмцэхэд саад болж байгаа хүчин зүйлс	44
Зураг 5.4	Авлигатай тэмцэхэд саад болж байгаа хүчин зүйлс (хүйсээр)	45
Зураг 5.5	Авлигатай тэмцэхэд саад болж буй хүчин зүйлс (судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн салбараар)	46
Зураг 5.6	Авлигыг тэмцэх арга хэмжээ (хүйсээр)	46
Зураг 5.7	Авлигатай тэмцэх арга хэмжээ (судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн салбараар)	47
Зураг 5.8	Одоогийн Засгийн газар өмнөх Засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ?	48
Зураг 5.9	Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг Та хэрхэн үнэлж байна вэ?	49
Зураг 5.10	Авлигатай тэмцэх газарт Та хэр зэрэг итгэдэг вэ?	49
Зураг 5.11	Та Авлигатай тэмцэх газар бие даасан, аль нэг улс төрийн хүчнээс хамааралгүй үйл ажиллагаа явуулж чаддагт итгэдэг үү?	50
Зураг 5.12	Авлигын эсрэг шинэ хууль батлагдсаны дараа Та шинэ хуулийн хүрээнд аль нэг албан тушаалтан шийтгүүлсэн тухай сонссон үү?	50
Зураг 5.13	Авлигатай Тэмцэх газарт авлигын талаар мэдүүлэх утас ажиллаж байгааг та мэдэх үү?	51
Зураг 5.14	Хэрвээ Авлигатай Тэмцэх газар нэг хаяггүй мэдээлэл хүлээж авна гэвэл та авлигын талаар мэдээлэл өгөх үү?	51
Зураг 6.1	Дараах арга хэмжээнүүд хэр ЧУХАЛ гэж та бодож байна вэ?	54

Зураг 6.2	Дараах арга хэмжээнүүд хэр ҮР ДҮНТЭЙ гэж та бодож байна вэ?	55
Зураг 7.1	Боловсролын салбар дахь шударга харьцаа	58
Зураг 7.2	Эрүүл мэндийн салбар дахь шударга харьцаа	59
Зураг 7.3	Шүүхийн тог толцооны шударга харьцаа	59
Зураг 7.4	Хууль сахиулах байгууллагын шударга харьцаа	60
Зураг 7.5	Орон нутгийн захиргааны шударга харьцаа	60
Зураг 7.6	Төрийн захиргааны шударга харьцаа	60
Зураг 7.7	Орон нутгийн захиргааны шударга харьцаа (салбараар)	61
Зураг 7.8	Төрийн захиргааны шударга харьцаа (салбараар)	61
Зураг 7.9	Шүүхийн тог толцооны шударга харьцаа (салбараар)	62
Зураг 7.10	Хууль сахиулах байгууллагын шударга харьцаа (салбараар)	62
Зураг 8.1	Дээд түвшиний авлигын тодорхойлолт	64
Зураг 8.2	Монгол дахь дээд түвшиний авлигын түвшин	65
Зураг 8.3	Дээд түвшний авлига Монголд яагаад оршиж байна вэ?	66
Зураг 8.4	Дээд түвшиний авлигын хэмжээний талаарх төсөөлөл	67
Зураг 8.5	Дээд түвшиний авлигын талаар олж сонсох	67
Зураг 8.6	Дээд түвшиний авлигын хэлбэрийн чиг хандлага	68
Зураг 8.7	Дээд түвшиний авлигын өрхүүдэд үзүүлэх нөлөө	69
Зураг 8.8	Дээд түвшний авлигатай тэмцэх ажлыг удирдах байгууллага	69
Зураг 8.9	Дээд түвшний авлига өрхүүдэд үзүүлэх нөлөө	70
Зураг 8.10	Дээд түвшний авлигатай тэмцэх хамгийн үр дүнтэй арга	71
Зураг 9.1	Авлига төлөхийг нэхсэн тохиолдолд үзүүлэх хариу үйлдэл	74
Зураг 9.2	Авлигын талаар хаана мэдэгдэх вэ?	75
Зураг 9.3	Хандив - хээл хахууль эсвэл байгууллагыг дэмжих нэг арга зам?	76
Зураг 9.4	Өрхийн түвшний хээл хахуулийн чиг хандлага	76
Зураг 9.5	Сүүлийн 3 сарын хугацаанд хахууль өгөх болсон гол шалтгаан юу байсан бэ?	77
Зураг 9.6	Хээл хахууль өрхийн төсөвт "ноцтой" хохирол үзүүлсэн чиг хандлага	77
Хүснэгт 1.	Түүврийн тархалт	10
Хүснэгт 2.	Авлигад хамгийн их өртсөн байгууллагууд	31
Хүснэгт 3.	Өрхийн түвшний хээл хахуулийн статистик мэдээ	78

ОРШИЛ

Азийн сан, Сант Марал сантай хамтран Авлигын Талаарх Олон Нийтийн Ойлголт Мэдлэг тогтоох (SPEAK) 17 дахь удаагийн судалгаагаа нийслэл Улаанбаатар хот болон аймаг, сумдыг хамруулан үндэсний хэмжээнд 2016 оны 3 дугаар сард хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааг Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр Азийн сангийн хэрэгжүүлж буй Төрийн албан дахь Ардчилсан оролцоо болон Ил тод байдлыг сайжруулах төслийн (STEPS) хүрээнд явуулж байна. Судалгаа 2006-2011 оны хооронд АНУ-ын ОУХА-ийн санхүүжилтээр “Монгол дахь Авлигын түвшинг тогтоох судалгаа” нэрээр хагас жил тутам хийгддэг байсан бол 2012 оноос “Авлигын Талаарх Олон Нийтийн Ойлголт Мэдлэг Тогтоох” судалгаа буюу SPEAK гэж нэрлэгдэх болсон. Тус судалгаагаар авлига, өндөр түвшиний авлига, төрийн байгууллагууд дахь авлигын талаарх олон нийтийн ойлголт, төсөөлөл, мэдлэг болон өрхийн түвшин дэх авлигын тохиолдол, түүний үр нөлөөг судлахыг зорьдог юм.

STEPS төсөл үргэлжлэх хугацааны туршид энэхүү судалгааг гурван удаа явуулна. Судалгааны үр дүн нь төсөл боловсруулах, мэдээлэл цуглуулах болон төслийн бусад үе шатуудад баримт, мэдээлэл болж өгдөгөөрөө онцлог юм. Судалгаа нь олон нийт, хувийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хувьд соён гэгээрүүлэх, ойлголт мэдлэг түгээх чухал арга хэрэгсэл болдог. Судалгааг тогтмол хугацаанд давтан явуулснаар олон нийтийн ойлголт, хандлагад гарч буй өөрчлөлтийг тодорхойлох ач холбогдолтой болдог. Түүнчлэн энэхүү судалгаанаас гадна бизнес эрхлэгчдийн ойлголт, төсөөллийг тодорхойлох зорилгоор Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааг мөн явуулдаг. Эдгээр судалгаануудаас Монгол улс дахь авлигын нөхцөл байдлын ерөнхий дүр зургийг харах боломжтой юм.

Энэхүү судалгааны тайланг 2016 оны 7-р сард олон нийтэд танилцуулав.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааг бүтэцлэгдсэн болон ганцаарчилсан ярилцлага авах хэлбэрээр 18 болон түүнээс дээш насны буюу насанд хүрэгчдээс авсан. Судалгаа нь санамсаргүй түүвэр болон магадлалын тархалтын аргачлалаар газар нутгийн бүлэглэлийн олон түвшнийг хамарсан.

Эхний шатанд Улаанбаатар хот болон Монгол улсын дөрвөн бүс нутаг бүрээс хоёр хүртэлх аймгийг түүврийн аргаар сонгож авсан. Эдгээр аймгуудаас сумдыг, Улаанбаатар хотоос хороодыг мөн санамсаргүйгээр сонгосон. Аймгийн төв болон сумын төвүүдийг түүвэрт зайлшгүй хамруулсан.

Хоёрдугаар шатанд Түүврийн Анхан Шатны Нэгжүүдийг (ТАШН) сонгосон. Улаанбаатар хотод ТАШН-үүдийг түүвэрлэгдсэн хороодоос сонгосон. Аймгийн төвүүдэд ТАШН-үүд засаг захиргааны хамгийн бага нэгж болох багууд байсан. Сумын төвүүдэд судалгааны багийн ахлагч өрхүүдийн бүлгийг тодорхойлсон. ТАШН нь найман өрхөөс тогтсон бүлгүүд байсан.

Гуравдугаар шатанд эхлэх цэг болон өрхүүдийг тодорхойлсон. Улаанбаатар хотын орон сууцны хорооллуудын байшин болон хаалганы дугаар бүхий хаягийг судлаачдад өгсөн. Гэр хорооллуудад ажлын ахлагч гудамжны дугаар болон эхлэх цэгүүдийг судлаачдад хуваарилсан. Гэр хороололд судлаачид эхлэх цэгээс эхний өрхийг алгасаад хоёр дахь өрхөөс эхлэн ярилцлага авч, үүний дараа баруун гарын дүрмийг баримтлан гурав дахь өрх бүрийг сонгон ярилцлагыг хийсэн. Аймгийн төв болон сумын төвүүдэд ахлагч эхлэх цэгийг тодорхойлсон ба судлаач баруун гарын дүрмээр гурав дахь өрх бүрийг сонгосон. Ярилцлагыг өрхийн тэргүүн эсвэл өрх гэрийн асуудлаар хамгийн их мэдлэгтэй хүнийг сонгож явуулсан.

Энэхүү тайланд 2016 оны 3-р сарын 12-ны өдрөөс 2016 оны 4-р сарын 4-ний хооронд хийгдсэн Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох VI дахь судалгааны үр дүнг танилцуулсан болно. Судалгаанд Улаанбаатар хотын найман дүүрэг, зургаан аймгийн 22 сумын нийт 1,360 айл өрхөөс бүрдсэн 170 анхан шатны нэгжүүд хамрагдсан¹. Түүврийн тархалтыг дараах хүснэгтэд харуулав:

¹ Үр дүнгүүд нь 18 ба түүнээс дээш насны 1,360 насанд хүрэгчдээс авсан ганцаарчилсан ярилцлага дээр суурилсан болно. Нийт улсын насанд хүрэгчдийн түүвэрт тулгуурласан үр дүнгийн хувьд түүврийн алдааны хязгаар ± 1.6 хувиас ($p = 10$ хувь бол, $1-p = 90$ хувь) ± 2.6 хувь ($x = 40$ хувь бол, $1-p = 60$ хувь) байх ба 95%-ийн итгэлийн түвшинд байна. Түүврийн алдаанаас гадна, асуултын үг хэллэг болон санал асуулга авах бодит хүндрэлүүд нь судалгааны гол үр дүнд алдаа болон нөлөөлөл үзүүлж болох юм.

Хүснэгт 1: Түүврийн тархалт

Бүс	Хот/Аймаг	Дүүрэг/Сум	Судалгаа авсан өрхүүд
	Улаанбаатар		600
		Хан-Уул	56
		Баянзүрх	144
		Сүхбаатар	72
		Чингэлтэй	72
		Баянгол	88
		Сонгинохайрхан	136
		Налайх	16
		Багануур	16
	Аймгууд		760
Баруун Бүс	Ховд		176
		Жаргалант (аймгийн төв)	64
		Эрдэнэбүрэн	24
		Мянгат	32
		Зэрэг	32
		Дарви	24
Хангайн Бүс	Булган		88
		Булган (аймгийн төв)	40
		Хангал	32
		Рашаант	16
	Өвөрхангай		168
		Арвайхээр (аймгийн төв)	64
		Хужирт	40
		Зүүнбаян-Улаан	32
		Баянгол	32
Төвийн Бүс	Дундговь		89
		Мандалговь (аймгийн төв)	40
		Гурвансайхан	25
		Лүүс	24
	Сэлэнгэ		135
		Сүхбаатар (аймгийн төв)	56
		Зүүнбүрэн	23
		Мандал (Зүүнхараа)	32
		Баруунбүрэн	16
		Хөтөл	8
Зүүн бүс	Сүхбаатар		104
		Баруун-Урт (аймгийн төв)	40
		Сүхбаатар	16
		Уулбаян	16
		Эрдэнэцагаан	32
	Нийт		1360

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

- Эдийн засгийн хүндрэл мөн удахгүй болох сонгуультай холбоотой улс төрийн тогтворгүй нөхцөл байдал 2016 оны судалгааны дүнд нөлөөлсөн харагдаж байна.
 - "Нийгэм эдийн засгийн хямрал" гэсэн ангилал тулгамдсан асуудлуудын зургадугаар байрнаас хоёрдугаар байр руу шилжжээ. Авлигын талаарх хандлага өмнөх жилүүдтэй адил хэвээр байна.
 - 2006 оноос хойш анх удаа улс төрийн намууд авлигад хамгийн их өртсөн байгууллагуудын жагсаалтыг тэргүүлээ. Өмнөх жилүүдэд газрын алба эхний байранд бичигддэг байв. Жагсаалтын эхний таван байгууллагын гурвыг нь улс төрийн байгууллагууд буюу улс төрийн намууд, УИХ, Засгийн газар эзэлж байна.
 - Сонгуулийн үйл явц "ил тод, шударга" явагдана гэдэгт олон нийт хангалттай итгэхгүй байна. 2015 онтой харьцуулахад судалгаанд оролцогчдын санал бодол дээрдсэн ч сонгуулийн компани т ажлын санхүүжилтийн ил тод, шударга байдалд олон нийт хамгийн итгэл багатай байна.
 - Оролцогчдын талаас илүү хувь нь сонгуулийн шинэ хууль "огт үр дүнгүй" эсвэл "маш бага үр дүнтэй" гэж үзэж байна (53.1 хувь).
- 2015 оны судалгааны үр дүнтэй адил судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь сүүлийн гурван жилд авлига нэмэгдсэн гэж үзэж байна (2015 онд 59 хувь, 2016 онд 58.8 хувь). Харин ирэх гурван жил авлига багасна гэсэн өөдрөг үзэл нэмэгджээ. 2016 онд судалгаанд оролцогчдын гуравны нэг нь ирэх гурван жилийн хугацаанд авлига буурна гэж хариулсан бол (34.9 хувь) энэ тоо 2015 онд 244 хувь байжээ.
- Авлигатай Тэмцэх Газрын (АТГ) үйл ажиллагаанд өгөх үнэлгээ 2015 оноос хойш их өөрчлөгдөөгүй боловч тус байгууллагын авлигын эсрэг тэмцэлд итгэх итгэл буурсаар байна. АТГ-ын хараат бус байдалд итгэх олон нийтийн итгэл 2014 онтой харьцуулахад мөн л багассан байна.
- Хүний нөлөөлөл, оролцоог багасгах шинэ техник, технологи нэвтрүүлэх мөн шинээр баталсан "Шилэн дансны хууль" зэргийг авлигын эсрэг үр дүнтэй санаачилга гэж үзжээ.
- Дээд түвшний авлигын нөлөөллийг тодорхойлох нь жирийн айл өрхүүдэд хүндрэлтэй хэвээр байна.
- Өрхийн төлж байгаа жижиг хээл хахуулийн дундаж хэмжээ 2015 оны 3 дугаар сард 277,000 төгрөг байсан бол 2016 оны 3 дугаар сард 336,000 төгрөг болж өссөн байна.


СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН




1. ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

2016 оны 3 дугаар сарын байдлаар "ажилгүйдэл" Монгол улсад хамгийн тулгамдсан асуудал хэвээр байна. 2015 онд 27.8 хувиас 2016 онд 28.4 хувь болж бага зэрэг нэмэгдэжээ. Өнгөрсөн жил хоёрдугаар байранд "инфляц" орж байсан бол энэ жил "Нийгэм эдийн засгийн хямрал" хоёрдугаарт жагсжээ. "Нийгэм эдийн засгийн хямрал" гэдэгт эдийн засгийн болон нийгмийн сөрөг үзэгдлүүдийг хамруулж ойлгоно. Энэхүү үзүүлэлт 2015 онд 5 хувь байсан бол 2016 онд 9.7 хувь болж хоёр дахин нэмэгдэжээ. "Ядуурал" тулгамдсан асуудлын гуравдугаар байрнаас тав руу шилжсэн байна. Судалгааны үндсэн асуудал болох "авлига" дөрөвдүгээр байранд хэвээр байна.

Зураг 1.1: 2016 он Тулгамдсан асуудлууд (нэг сонголттой, нээлттэй асуулт)




Зураг 1.2: 2015 он Тулгамдсан асуудлууд (нэг сонголттой, нээлттэй асуулт)




Судалгаа хийгдэж байх хугацаанд ажилгүйдэл тулгамдсан асуудлын дунд нэлээдгүй дээгүүрт орохын зэрэгцээ хэлбэлзэл ихтэй байсан юм (Зураг 1.3). Харьцуулалт хийж үзэхэд авлига үндсэн асуудлын хувь хэмжээ нь буурсан байна (Зураг 14). Энэ нь эдийн засгийн хүндрэлийн асуудлууд олон нийтийн анхаарлыг илүү татаж байгаатай холбоотой байж болох юм.

"Ажилгүйдэл" болон "Авлига"-ын талаархи хандлагыг судалгаанд оролцогчдын насаар нь ангилж үзэхэд (Зураг 1.5) 18-39 насны иргэд ажилгүйдлийн асуудалд илүү их санаа зовж байгаа бол 30-39 насны бүлгийн хувьд авлигын талаар илүү санаа зовж байна.


Зураг 1.3: Ажилгүйдэл



Зураг 14: Авлига




Зураг 1.5: "Ажилгүйдэл" болон "Авлига"-ыг насны бүлгээр харьцуулсан байдал




Авлигыг тулгамдсан асуудал гэж үзэх нь боловсролын түвшинтэй шууд хамааралтай байдал ажиглагдаж байна (Зураг 1.6). Дунд сургуулийн боловсролтой оролцогчдын дөнгөж 4.3 хувь нь харин дээд боловсролтой оролцогчдын 12.1 хувь авлигыг асуудал гэж үзжээ.

Зураг 1.6 "Ажилгүйдэл" болон "Авлига"-ыг боловсролын түвшинээр харьцуулсан байдал




Хөдөө орон нутгийн иргэд хот суурин газарт амьдардаг иргэдээс илүүтэйгээр "ажилгүйдэл"-ийг гол асуудал гэж үзэж байна (Зураг 1.7). Хөдөө орон нутагт 31.5 хувь нь "Ажилгүйдэл"-ийг асуудал гэж үзсэн бол хот суурин газрын оролцогчдын дөнгөж 23.4 хувь ийм бодолтой байна. Харин авлигын талаархи хандлагын хувьд үүний эсрэг үзүүлэлт гарчээ. Хөдөө орон нутгийн оролцогчдоос (6 хувь) суурин газрын оролцогчид (9.8 хувь) "Авлига"-ыг гол асуудал гэж хэлэх нь илүү байна.

Зураг 1.7: "Ажилгүйдэл" болон "Авлига"-ыг судалгаанд оролцогчдын оршин суугаа газраар харьцуулсан байдал



Эмэгтэй оролцогчид "Ажилгүйдэл"-ийг гол асуудал гэж үзэх нь мөн илүү байна. "Авлига"-ыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан асуудал гэж үзсэн байхад эмэгтэй хүмүүс "Ажилгүйдэл"-ийн талаар эрэгтэй хүмүүсээс 4.7 хувиар илүү санаа зовдог байна (Зураг 1.8).

Зураг 1.8: "Ажилгүйдэл" болон "Авлига"-ыг судалгаанд оролцогчдын хүйсээр харьцуулсан байдал



СОНГУУЛИЙН ИЛ ТОД, ШУДАРГА БАЙДАЛ




2. СОНГУУЛИЙН ИЛ ТОД, ШУДАРГА БАЙДАЛ

2012 оны Галлап (Gallup) санал асуулгын нэг хэсэг болгож оролцогчдоос дараах асуултуудыг асуусан, "[Улсын нэр]-д та дараах зүйлүүдэд итгэлтэй байдаг уу, үгүй юу? Сонгуулийн шударга талаар ямар бодолтой байгаа вэ?" Монголын ардиргэд сонгуулийн явцад маш бага итгэлтэй байгааг үрдүн харуулсан.² Судалгаа хийгдсэн 140 гаруй орноос Монгол улс Орос, Пакистан, Афганистан болон Чад улсуудтай сүүлийн тавд бичигдсэн. 2012 оны судалгаа нь УИХ-ын сонгуулийн дараа 6 сард хийгдсэн ба олон нийт итгэл үнэмшилгүй болсон нь зарим талаараа энэхүү сонгуульд санал тоолох машин нэвтрүүлсэнтэй холбоотой байж болох юм. Хяналтыг нэмэгдүүлэх мөн энэ үл итгэлийг арилгах зорилгоор Монгол улсын ирэх 2016 оны сонгуулийн санал хураах хэсгүүдийн талыг нь санамсаргүй байдлаар сонгон авч саналын хуудасуудыг гар аргаар дахин тоолох юм.

Энэхүү олон нийтэд зарлаж байгаа санал тоолох явцын хяналтыг сайжруулах арга хэмжээ нь яагаад ард иргэдийг санал авах хэсэг дэх саналын тооллого болон Сонгуулийн Ерөнхий Хорооны (СЕХ) нэгдсэн санал тооллогын аль алинд итгэх итгэл 2016 онд 2015 онтой харьцуулахад бага зэрэг өндөр байгааг тайлбарлаж болох юм.

Энэ нь бага зэргийн өсөлт хэдий ч, сонгуулийн ил тод, шударга байдлын талаарх тэдний хүлээлт ямар байгааг асуухад, 2015 болон 2016 онуудад сонгуулийн бэлтгэл үе шатанд судалгаанд оролцогчдын 34 хувь нь "огт шударга бус" байна (Зураг 2.1) гэсэн хүлээлтэй байсан ба энэ хугацаанд бүх оролцогчдын итгэлийн дундаж түвшин сонгуулийн энэ үе шатанд 2.17-с 2.10 болж буурсан (Зураг 2.6).


Зураг 2.1: Сонгуультай холбоотой дараах үйл ажиллагаа хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? Бэлтгэл үе шат.



²Мэдээллийг харна уу: <https://sites.google.com/site/electoralintegrityproject4/projects/existing-datasets/public-perceptions>.


Сонгуулийн үе шатнаас оролцогчид сонгуулийн компани ажлын санхүүжилтэд хамгийн итгэл багатай байна. Судалгаанд оролцогчдын бараг тал нь (45 хувь) сонгуулийн компани ажлын санхүүжилтийг "огт ил тод биш" гэж үзсэн (Зураг 2.2). Энэ дүн 2015 оны байдлаар бага зэрэг буюу 7.7 хувийн өсөлттэй ажиглагдаж байсан юм. Дундаж дүнг харьцуулан харвал компани ажлын санхүүжилтийн ил тод байдалд итгэх итгэл мөн үеийнхээс 1.8-аас 1.91 болж өссөн (Зураг 2.6).

Зураг 2.2: Сонгуультай холбоотой үйл ажиллагаа хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? Компани ажлын санхүүжилт.




2016 онд судалгаанд оролцогчдын тавны нэг нь сонгуулийн кампанит ажил "огт ил тод биш" (20.9 хувь) гэж хариулсан бол 2015 онд оролцогчдын дөрөвний нэг нь (26.2 хувь) ийм бодолтой байжээ (Зураг 2.3). Дундаж үзүүлэлтүүдийг харьцуулахад судалгаанд оролцогчдын итгэлийн дундаж түвшин статистикийн хувьд маш бага өсөлтийг харуулж байна. 2015 оны 245 хувь харин 2016 онд 248 хувь (Зураг 2.6).

Зураг 2.3: Сонгуультай холбоотой үйл ажиллагаа хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? Сонгуулийн сурталчилгаа.




Санал тоолох үйл явцад итгэх итгэл 2016 онд нэмэгджээ. Үүнд автомат санал тооллогын үр дүнг давхар гараар тоолох шийдвэр гарсан нь нөлөөлсөн байж болно (Зураг 24). 2015 онд судалгаанд оролцогчдын 31.8 хувь санал тоолох явц "огт ил тод биш" гэж үзэж байсан бол 2016 онд энэ үзүүлэлт 25.9 хувь болж буурсан байна. Дундаж үзүүлэлтийн үнэлгээгээр итгэлийн дундаж түвшин 2.28-аас 2.37 болж сайжирчээ (Зураг 2.6).

Зураг 24: Сонгуультай холбоотой үйл ажиллагаа хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? Санал тоолох.




СЕХ-ны нэгдсэн тооллого болон тэдгээрийн танилцуулж байгаа мэдээлэл "огтхон ч" ил тод болон шударга биш гэж үзэх оролцогчдын тоо 2015 онд 29 хувь байсан нь 2016 онд 24.4 хувь болж буурчээ (Зураг 2.5). Итгэлийн дундаж үзүүлэлт 2.38-аас 2.44 болж өссөн байна (Зураг 2.6).

Зураг 2.5: Сонгуультай холбоотой үйл ажиллагаа хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ? Сонгуулийн дүнг нэгтгэх.




Зураг 2.6 Дундаж үзүүлэлтийн харьцуулалт (1 – "огт үгүй", 4 – "их хэмжээгээр" ил тод)



УИХ-ийн сонгууль болгоны өмнө сонгуулийн хуулинд өөрчлөлт оруулдаг ч энэхүү түвэгтэй, цаг хугацаа шаардсан үйл явцыг олон нийт сөргөөр үнэлж байна (Зураг 2.7). Судалгаанд оролцогчдын 38 хувь нь сонгуулийн хуулийн өөрчлөлтүүдийг "ихээхэн" эсвэл "маш их" ач холбогдолтой гэж үзсэн бол судалгаанд оролцогчдын талаас илүү хувь буюу 53.1 хувь нь одоогийн УИХ-аар танилцуулсан сонгуулийн хуулийн нэмэлтүүдийг "огт үгүй" эсвэл "бага зэрэг" л үр дүнтэй байсан гэж хариулжээ. Иргэдийн дургүйцэл ихээр байгаа ч гэсэн сонгуулийн хуулинд байнга өөрчлөлт оруулдаг байдал өөрчлөгдөхгүй байна.

Зураг 2.7. Сонгуулийн шинэ хуулийн ач холбогдол болон үр нөлөө




АВЛИГЫН ТҮВШИН



3. АВЛИГЫН ТҮВШИН

2006 оноос хойш авлига хувийн амьдрал, бизнесийн орчин, улс төрийн амьдралд үзүүлэх нөлөө нь судалгаанд оролцогчдын хувьд ихэнхдээ тогтвортой байна. Авлигын нөлөөний дундаж утга (1 - "огт" авлигын нөлөөлөл байхгүй, 4 - "их хэмжээгээр" авлигын нөлөөлөл өртсөн) маш бага хэлбэлзэлтэй байсан. Хувийн амьдралд авлигын нөлөөлөл буурсан байгааг Зураг 3.1 дээрх шугамнаас харж болно. Бизнесийн орчинд бага хэмжээний бууралт ажиглагдаж байхад улс төрийн орчинд авлигын мэдрэгдэх нөлөөлөл бага зэрэг нэмэгдсэн байна.


Зураг 3.1: Авлигын нөлөөлөл




Улс төрд авлигын үзүүлэх нөлөө нэмэгдэж байгаа гэх үзэл байгууллагуудын үнэлгээнд мөн харагдаж байна. 2006 оноос хойш анх удаа улс төрийн намүүд авлигад хамгийн их автсан байгууллагуудын жагсаалтыг тэргүүлж байна. (Зураг 3.2). Оролцогчдын гуравны нэг гаруй нь (35.6 хувь) улс төрийн намүүд "маш их" авлигад автсан гэж үзсэн (Зураг 3.4). Оролцогчдын гуравны нэг нь (33.3 хувь) газрын албыг "маш их" авлигад автсан гэж үзэж жагсаалтын хоёрт бичигдэж байна.

2015 оны адилаар, УИХ, Улс төрийн намүүд, Засгийн газар гурав авлигад хамгийн их автсан байгууллагын жагсаалтын эхний тавд багтаж байна. 2010 оны 3 дугаар сарын судалгаанаас хойш эдгээр гурван байгууллага тэргүүлэх байр руу тогтвортойгоор ахисан явцыг Хүснэгт 2-оос харна уу. Энэхүү нөхцөл байдлаас үүдэн "Нийгэм эдийн засгийн хямрал" улс орны тулгамдсан асуудлуудын хоёрдугаар байранд орсон гэж дүгнэж болохоор байна (Зураг 1.1).


Зураг 3.2: Авлигын тархалт, 2016 (1 – "огт үгүй" - 5 – "маш ихээр" авлигад автсан)



Зураг 3.3: Авлигын тархалт, 2015 (1 – "огт үгүй", 5 – "маш ихээр" авлигад автсан)



Зураг 34: 2016 оны авлигын үнэлгээ (салбараар)




Хүснэгт 2. Авлигад хамгийн их автсан байгууллага

Огноо	1-р зэрэглэл	2-р зэрэглэл	3-р зэрэглэл	4-р зэрэглэл	5-р зэрэглэл
03.2006	Газар ашиглалт	Гааль	Уул уурхай	Шүүгч	Цагдаагийн байгууллага
09.2006	Газар ашиглалт	Гааль	Уул уурхай	Шүүгч	Цагдаагийн байгууллага
03.2007	Газар ашиглалт	Гааль	Уул уурхай	Шүүгч	Бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээ
09.2007	Газар ашиглалт	Уул уурхай	Гааль	Бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээ	Шүүгч
03.2008	Газар ашиглалт	Уул уурхай	Гааль	Бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээ	Шүүгч
09.2008	Газар ашиглалт	Уул уурхай	Гааль	Шүүгч	Прокурор
03.2009	Газар ашиглалт	Уул уурхай	Шүүгч	Гааль	Прокурор
09.2009	Газар ашиглалт	Шүүгч	Цагдаагийн байгууллага	Прокурор	Уул уурхай
03.2010	Газар ашиглалт	Уул уурхай	Улс төрийн намууд	Гааль	УИХ/Хууль тогтоох байгууллага
09.2010	Газар ашиглалт	Уул уурхай	Шүүгч	Гааль	Улс төрийн намууд
04.2011	Газар ашиглалт	Уул уурхай	Шүүгч	Гааль	Улс төрийн намууд
11.2012	Газар ашиглалт	Уул уурхай	Орон нутгийн ханган нийлүүлэх тендерууд	Мэргэжлийн хяналтын газар	Улс төрийн намууд
0.2013	Газар ашиглалт	Уул уурхайн Төрийн удирдлага	Орон нутгийн ханган нийлүүлэх тендерууд	Улс төрийн намууд	Гааль
09.2013	Газар ашиглалт	Уул уурхайн Төрийн удирдлага	Орон нутгийн ханган нийлүүлэх тендерууд	Улс төрийн намууд	Уул уурхайн салбар дахь хувийн компаниуд
03.2014	Газар ашиглалт	Уул уурхайн Төрийн удирдлага	Орон нутгийн ханган нийлүүлэх тендерууд	Шүүгч	Гааль
04.2015	Газар ашиглалт	Улс төрийн намууд	Уул уурхай	Засгийн газар	УИХ/Хууль тогтоох байгууллага
03.2016	Улс төрийн намууд	Газар ашиглалт	Уул уурхай	УИХ/Хууль тогтоох байгууллага	Засгийн газар

2016 оны байгууллага тус бүрийн авлигын дундаж түвшинг судалгаанд оролцогчдын хүйсээр хүснэгтэлж үзвэл онцын ялгаа харагдахгүй байна (Зураг 3.5). Эмэгтэйчүүд эрүүл мэнд, боловсрол, орон нутгийн засаг захиргаа болон уул уурхайн талаар арай илүү зэрэг үнэлгээтэй байна. Эрэгтэйчүүд банк, санхүү, бүртгэл болон зөвшөөрлийн үйлчилгээ, мэргэжлийн хяналтын байгууллага, гааль, татварын алба болон засгийн газрыг илүү зэрэгээр үнэлжээ.

Зураг 3.5: 2016 оны авлигын үнэлгээ, хүйсээр (1 – "огтгүй", 5 – "маш ихээр" авлигад автсан)




Харин авлигад автсан байгууллагын үнэлгээг судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдлаар нь ангилж үзэхэд хэлбэлзэл илүү их ажиглагдлаа (Зураг 3.6). Судалгаанд оролцогчдын санал бодлыг ажил эрхлэлтийн байдлаар хүснэгтэлж үзвэл (хуваарилалтыг Зураг 4.7 харна үү):

- Төрийн албан хаагчид
- Төрийн үйлчилгээний ажилтнууд (улсын төсвөөс цалин авдаг)
- Хувийн байгууллага (хувийн хэвшил)
- Төрийн бус (иргэний нийгэм)

Ажил эрхлэлтийн салбараар авч үзвэл төрийн бус байгуулагад ажилладаг оролцогчид татварын алба, орон нутгийн засаг захиргаа, хууль сахиулах байгууллага болон шүүхийн тогтолцоог илүү сөргөөр үнэлсэн. Судалгаанд оролцсон төрийн албан хаагчид улс төрийн намууд болон засгийн газрын талаар илүү шүүмжлэлтэй байсан бол орон нутгийн засаг захиргааны талаар сөрөг үнэлгээ арай бага байсан нь тухайн байгууллагын удтай хамтарч ажилладагтай холбоотой байж болох юм.

Хувийн хэвшлийн оролцогчид УИХ, Бүртгэл болон зөвшөөрлийн үйлчилгээний талаар илүү шүүмжтэй байсан бөгөөд газрын асуудал эрхэлсэн албаны талаар төрийн бус байгууллагын оролцогчидтой адил үзэл бодолтой байна.

Зураг 3.6: Авлигад автсан байгууллагуудын зэрэглэл - судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн салбараар (1 – "огт үгүй", 5 – "маш ихээр" авлигад автсан)




АВЛИГЫН ЧИГ ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ




4. АВЛИГЫН ЧИГ ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ

2016 онд судалгаанд оролцогчдын дунд авлигын түвшний гурван жилийн чиг хандлагын талаар мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй. Судалгаанд оролцогчдын тэн хагас нь сүүлийн гурван жилийн хугацаанд авлига өссөн хэмээн үзэж байгаа нь өнгөрсөн оны үзүүлэлттэй адил байгаа юм (2016 онд 58.8 хувь, 2015 онд 59.0 хувь: Зураг 4.1). Харин ирээдүйн төлөв байдлын талаар оролцогчид илүү өөдрөгөөр хариулжээ. 2015 онд судалгаанд оролцогчдын 244 хувь нь ирэх гурван жилд авлига буурна хэмээн үзэж байсан бол 2016 онд 34.9 хувь нь ийм бодолтой байна (Зураг 4.2).

Зураг 4.1: Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?




Зураг 4.2: Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ?




Авлигын чиг хандлагын үзүүлэлтийг хүйсээр харвал 2016 онд эрэгтэйчүүдийн 29.4 хувь, эмэгтэйчүүдийн 26.8 хувь авлига сүүлийн гурван жилд нэмэгдсэн гэж үзсэн (Зураг 4.3). Үүний адил эрэгтэйчүүдийн 12.7 хувь, эмэгтэйчүүдийн 11.4 хувь ирэх гурван жилийн хугацаанд авлига нэмэгдэнэ гэж хариулсан байна (Зураг 4.4). Энэхүү зөрүү нь статистикийн хувьд ач холбогдол багатай бөгөөд бусад асуултуудын хувьд ч зөрүү ихэвчлэн ижил байсан.

Зураг 4.3: Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? (Хүйсээр)




Зураг 44: Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ? (Хүйсээр)




Авлигын чиг хандлагыг ажил эрхлэлтийн салбараар авч үзвэл төрийн бус байгууллагын оролцогчдын хариулт их ялгаатай байна. Энэхүү салбарын оролцогчдын бараг тал нь авлига "маш их нэмэгдсэн" гэж үзэж байхад (44.8 хувь), бусад гурван салбарын дундаж нь дөрөвний нэгээс бага зэрэг илүү байна (Зураг 4.5). Судалгаанд хамрагдсан төрийн бус байгууллагын нэг ч оролцогч (0.0 хувь) авлига ирэх гурван жилд "их хэмжээгээр буурна" гэж үзэхгүй байхад бусад салбарын оролцогчдод ийм итгэл найдвар байна (Зураг 4.6).


Зураг 4.5: Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? (Ажил эрхлэлтийн салбараар)



Зураг 4.6: Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ? (Ажил эрхлэлтийн салбараар)



Зураг 4.7: Хүн амын тархалт ажил эрхлэлтийн салбараар




АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ



5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ


Олон нийтийн санал бодол "Авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой" талаар 2015 оныхтой ижил хэвээрээ байна (Зураг 5.1). 2015 онд 37.8 хувь, 2016 онд 38.3 хувьтайгаар авлигатай тэмцэх тэмцлийг Авлигатай тэмцэх газар (АТГ) тэргүүлж байна. Нэгэн чухал өөрчлөлт нь "Хууль сахиулах байгууллага" гэсэн сонголт 2015 онд 8.8 хувиас 2016 онд 11.3 хувь болж өссөн явдал юм.

Зураг 5.1: Авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ?




Авлигатай тэмцэх арга замд “хүчтэй арга хэмжээ авах, хатуу шийтгэл оногдуулах” гэсэн хариулт өссөн харагдаж байна (Зураг 5.2). Энэ хариулт 2015 оны 21.4 хувиас 2016 онд 24.6 хувь болж өсчээ. “Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх” гэсэн хандлага 2015 оны 8.3 хувиас 2016 онд 10.5 хувь болж өсөхөд айл өрхүүдэд хүндээр тусч буй эдийн засгийн хүндрэл нөлөөлсөн гэж үзэж болохоор байна. “Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх” арга хэрэгсэл 2015 оны 9.9 хувиас 2016 онд 8.6 хувь болж 2012 оны түвшинд хүрчээ. 2015 онтой харьцуулахад 2016 онд цөөн тооны хүмүүс захиргааны байгууллагын үйл ажиллагаанд төрийн зүгээс тавих хяналтыг хүчтэй болгохыг дэмжсэн бөгөөд иргэд, төрийн бус байгууллагуудын зүгээс тавих хяналтыг нэмэгдүүлэх нь үр дүнтэй гэжээ. “Засаг захиргааны шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, ил тод болгох”-ыг дэмжсэн хүмүүс 2015 онд 15.3 хувиас 2016 онд 12.9 хувь болж буурчээ.

Зураг 5.2: Авлигатай тэмцэх үр дүнтэй арга замууд




2016 онд судалгаанд оролцогчид авлигатай тэмцэхэд саад болж буй хүчин зүйлүүдэд бага ач холбогдол өгсөн байна (Зураг 5.3). "Авлигатай тэмцэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, хүлээлгэх ял шийтгэл боловсронгуй биш" гэсэн хүчин зүйл хамгийн ихээр бүүрсан боловч "Асуудлыг хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл болсон" гэж үзсэн хүмүүсийн тоо хэвээрээ байна.

Зураг 5.3: Авлигатай тэмцэхэд саад болж байгаа хүчин зүйлс (1 – "огт үгүй", 4 – "маш ихээр")




Саад тотгор болж байгаа хүчин зүйлүүдийн хариултанд хүйсийн ялгаа ажиглагдаагүй (Зураг 5.4). Ажил эрхлэлтийн байдлаар авч үзэхэд төрийн бус байгууллага болон төрийн албан хаагчдийн хооронд томоохон ялгаа гарсан (Зураг 5.5). "Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад орон нутгийн түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй", "Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад улс орны түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй" болон "Төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ур чадвар муу" гэсэн хүчин зүйлүүд хамгийн их зөрүүтэй байв. Төрийн үйлчилгээний салбарын оролцогчид "Асуудлыг хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл болсон" болон "Хууль сахиулах байгууллагын хүрээнд авлига газар авсан" зэрэгт хамгийн их шүүмжлэлтэй байна.

Зураг 5.4: Авлигатай тэмцэхэд саад болж байгаа хүчин зүйлс (хүйсээр)



Зураг 5.5: Авлигатай тэмцэхэд саад болж буй хүчин зүйлс
(судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн салбараар)




Авлигатай тэмцэх арга хэмжээний хариулт дээр хүйсийн ялгаа илүүтэйгээр харагдсан (Зураг 5.6). Эмэгтэйчүүд "Хуулиа тогтвортой хэрэгжүүлэх", "Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх" мөн "Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх" арга хэрэгслийг илүү дэмжжээ. Харин эрэгтэйчүүд "Засаг захиргааны шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, ил тод болгох" болон "Иргэд, төрийн бус байгууллагуудын зүгээс тавих хяналтыг хүчтэй болгох" ажлуудыг илүүд үзсэн.

Зураг 5.6: Авлигатай тэмцэх арга зам (хүйсээр)




Авлигын эсрэг авах арга хэмжээг оролцогчдын ажил эрхлэлтийн салбараар ангилж үзэхэд сонирхолтой дүр зураг харагдаж байна (Зураг 5.7). Хувийн хэвшлийн оролцогчид хуулийг тогтвортой хэрэгжүүлэх (17.7 хувь) болон төрийн зүгээс захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгохыг (14.8 хувь) тэргүүнд тавьжээ. Тэд төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхийг хамгийн бага үр дүнтэй гэж үзсэн (9.1 хувь). Харин төрийн албаны оролцогчид энэ сонголтыг илүүд үзсэн (19 хувь). Хүчтэй арга хэмжээ авах, хатуу шийтгэл оногдуулах нь төрийн үйлчилгээний ажил эрхэлдэг оролцогчдын хувьд хамгийн тэргүүлэх сонголт байсан (26.9 хувь).

Зураг 5.7: Авлигатай тэмцэх арга зам (судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн салбараар)




2016 онд судалгаанд оролцогчид одоогийн Засгийн газрын авлигатай тэмцэх үйл ажиллагаа өмнөх Ерөнхий сайд Н.Алтанхуягийн Засгийн газраас (2012-2014) үрдүн багатай гэж үзсэн хэвээрээ байна. Судалгаанд оролцогчдын дөнгөж 8 хувь нь одоогийн засгийн газар илүү сайн байх болно гэж үзсэн бол 30.1 хувь нь мүү байна гэж үзжээ (Зураг 5.8).

Зураг 5.8: Одоогийн Засгийн газар өмнөх Засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ?




Засгийн газарт өгсөн үнэлгээний нэгэн адилаар 2016 онд судалгаанд оролцогчид АТГ-ыг мөн сөргөөр үнэлжээ. Оролцогчдын ердөө 14 хувь АТГ-т эерэг, 44.9 хувь нь сөрөг үнэлгээ өгчээ (Зураг 5.9). Түүнчлэн итгэл үнэмшлийн түвшин буурчээ (Зураг 5.10). 2015 онд судалгаанд оролцогчдын 39.2 хувь АТГ-ын үйл ажиллагаанд итгэлтэй байсан бол 2016 онд энэ тоо 31.9 хувь болж буурсан байна.

Зураг 5.9: Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг Та хэрхэн үнэлж байна вэ?




Зураг 5.10: Авлигатай тэмцэх газарт Та хэр зэрэг итгэдэг вэ?




2016 онд олон нийтийн 22.1 хувь нь АТГ-ыг хууль сахиулах хараат бус байгууллага гэж үзэж байгаа нь 2015 оны 21.7 хувиас нэг их өөрчлөгдөөгүй байна (Зураг 5.11). “Авлигын хэргээр шийтгэл хүлээсэн албан тушаалтнуудын тухай мэднэ” хэмээн хариулсан иргэдийн тоо бага хэмжээгээр буюу 40.4 хувиас 43.2 хувь болж өссөн (Зураг 5.12) боловч 2013 оны 9 дүгээр сард хүрсэн 51.6 хувиас хамаагүй бага байна. Авлигын тухай мэдээлэх утасны талаарх ард иргэдийн мэдлэг 2015 оны 24.9 хувиас 2016 онд 29 хувь болж өссөн хэдий ч (Зураг 5.13), нэрээ нууцлан авлигын талаар мэдээлэх иргэдийн хувь 56-аас 50.3 хувь болж буурсан байна (Зураг 5.14).


Зураг 5.11: Та Авлигатай тэмцэх газар бие даасан, аль нэг улс төрийн хүчнээс хамааралгүй үйл ажиллагаа явуулж чаддагт итгэдэг үү?




Зураг 5.12: Авлигын эсрэг шинэ хууль батлагдсаны дараа Та шинэ хуулийн хүрээнд аль нэг албан тушаалтан шийтгүүлсэн тухай сонссон үү?



Зураг 5.13: Авлигатай тэмцэх газарт авлигын талаар мэдүүлэх утас ажиллаж байгааг та мэдэх үү?



Зураг 5.14: Хэрвээ авлигатай тэмцэх газар нэг хаяггүй мэдээлэл хүлээж авна гэвэл та авлигын талаар мэдээлэл өгөх үү?



АВЛИГЫН ЭСРЭГ САНААЧИЛГА




6. АВЛИГЫН ЭСРЭГ САНААЧИЛГА

Авлигын эсрэг санал санаачилгыг иргэд илүү бодитоор үнэлсэн. Хүний оролцоотой үйл ажиллагааг багасгах шинэ техник, технологи нэвтрүүлэх ажилд хамгийн их ач холбогдол өгчээ (Зураг 6.1). Судалгаанд оролцогчдын бараг тал нь үүнийг "маш их" ач холбогдолтой гэж үзэж гуравны нэг орчим нь "ихээхэн" ач холбогдолтой гэж хариулсан байна (тус тус 37.8 хувь ба 28.2 хувь).

Авлигатай тэмцэх хамгийн чухал үйл ажиллагааны хоёрдугаарт "Нягтлан бодох бүртгэлийн ил тод тухай хуулийг нэвтрүүлэх" оржээ. Судалгаанд оролцогчдын 29 хувь үүнийг "маш их" чухал гэж үзэж байна. Оролцогчдын саналыг ихээр авсан өөр нэгэн санаачилга нь төрийн албан хаагчдаас хөрөнгө орлогын мэдүүлгийг тогтмол гаргуулж авах бөгөөд оролцогчдын 25 хувь үүнийг "маш их" ач холбогдолтой гэж үзсэн.


Судалгаанд оролцогчдын дөрөвний нэг нь сонгуулийн шинэ хуулийн талаар ямар нэгэн хариулт өгөөгүй, тавны нэг нь өршөөлийн хуулийн талаар ямар нэг санал бодолгүй байсан (тус бүр нь 26 хувь ба 18.8 хувь). Эдгээр хуулиудад бага ач холбогдол өгсөн бөгөөд оролцогчдын дөнгөж 13.4 хувь өршөөлийн хуулийг, 14.8 хувь сонгуулийн хуулийг "маш их" ач холбогдолтой гэж үзжээ.

Зураг 6.1: Дараах арга хэмжээнүүд хэр ЧУХАЛ гэж та бодож байна вэ?



Судалгаанд оролцогчид авлигын эсрэг санаачилгуудын үр дүнгийн талаар мөн ижил хандлагатай байна. Тэдгээрийн дийлэнх нь өршөөлийн хууль болон сонгуулийн шинэ хууль үр дүнтэй эсэх дээр ямар нэгэн санал бодолгүй байв (Зураг 6.2). Иргэд шинэ технологи нэвтрүүлэх нь хамгийн өндөр үр дүнтэй гэж тэмдэглэсэн. Оролцогчдын дөрөвний нэг нь энэхүү арга хэмжээг "маш их" үр дүнтэй гэж үзсэн бөгөөд дөрөвний нэг гаруй нь "нэлээд их" үр дүнтэй гэж хариулсан (25.1 хувь ба 26.9 хувь). Судалгаанд оролцогчид өдөр тутмын амьдралдаа "Цахим бүртгэл" болон нэг цонхны үйлчилгээг ашиглах нь илүү байдаг учраас тэдгээрийг гэж үнэлсэн байж болох юм. Хуулийн санаачилгын үр дүн урт хугацаанд илэрдэг тул илүү алслагдмал, үнэлэхэд хүндрэлтэй байдаг.

Зураг 6.2: Дараах арга хэмжээнүүд хэр ҮР ДҮНТЭЙ гэж та бодож байна вэ?



ШУДАРГА ХАНДЛАГА




7. ШУДАРГА ХАНДЛАГА


2015 оны нөхцөл байдалтай харьцуулахад “шударга бус хандана” гэсэн үзэл орон нутгийн засаг захиргаанаас гадна үнэлгээ хийгдсэн бүх салбаруудад их хэмжээгээр буурсан байна. Боловсролын салбарт шударга бус хандана гэсэн хариулт 2015 оны 48.1 хувиас 2016 онд 42.2 хувь болж буурсан (Зураг 7.1). Эрүүл мэндийн салбарт 2015 онд 56.8 хувь байснаас 2016 онд 52 хувь болж буурчээ (Зураг 7.2). Шүүхийн тогтолцоонд 65.5 хувиас 59.1 хувь болсон (Зураг 7.3). Хууль сахиулах байгууллагын хувьд 64.9 хувиас 58.8 хувь болж буурсан байна (Зураг 7.4). Харин орон нутгийн засаг захиргаа шударга бус хандана гэж үзсэн оролцогчдын хувь хэмжээ 2016 онд үндсэндээ өөрчлөгдөөгүй 2015 оны 48.0 хувьтай харьцуулахад 48.2 хувь хэвээр байна (Зураг 6.5). Засгийн газрын хувьд шударга бус хандалт 2015 онд 56.2 хувиас 2016 онд 52.5 хувь болж буурсан байна (Зураг 6.6).

Ерөнхийдөө судалгаанд оролцогчдын тэн хагас нь эдгээр байгууллагууд шударга хандана гэдэгт итгэхгүй байгаа болохоор хүлээлт нэлээн доогуур байгаа ч гэсэн эдгээр тоо нь өмнөх судалгааны үр дүнгээс сайжирсан байна. Хамгийн том өөрчлөлт хууль сахиулах байгууллага болон шүүхийн тогтолцооны салбарт гарсан байна. Авлигын Талаарх Олон Нийтийн Ойлголт Мэдлэг Тогтоох судалгаа анх явуулж байхад оролцогчдын бараг дөрөвний гурав нь шударга бус хандах хүлээлттэй байсан. Сүүлийн үеийн судалгаагаар энэхүү хувь хэмжээ нь буурсаар байна.

Зураг 7.1: Боловсролын салбар дахь шударга хандлага




Зураг 7.2: Эрүүл мэндийн салбар дахь шударга хандлага




Зураг 7.3: Шүүхийн тогтолцооны шударга хандлага




Зураг 74: Хууль сахиулах байгууллагын шударга хандлага



Зураг 75: Орон нутгийн захиргааны шударга хандлага




Зураг 76: Төрийн захиргааны шударга хандлага




Шударга хандах хүлээлтийг ажил эрхлэлтийн салбараар ангилж үзэхэд төрийн албан хаагчид нь төрийн байгууллагуудад илүү талтай байх хандлага ажиглагдсан. Энэхүү өрөөсгөл байдал нь эрүүл мэнд, боловсрол зэрэг хувийн хэвшлийн оролцоо тодорхой байдаг салбарт илт ажиглагдахгүй байгаа. Орон нутгийн засаг захиргааны түвшинд төрийн бус салбарын оролцогчид 20 хувь, хувийн хэвшлийн оролцогчид 15 хувийн "шударга бус" хандах хүлээлттэй байна (Зураг 77). Тухайлбал төрийн үйлчилгээний салбарт ажил эрхэлдэг судалгаанд оролцогчдын 11.9 хувь, төрийн албан хаагчдын ердөө 8.3 хувь Орон нутгийн засаг захиргаа "шударга бус" хандана гэсэн хүлээлттэй байна. Төрийн бус болон хувийн хэвшлийн салбарынхан нийлээд хөдөлмөр эрхэлж буй нийт хүн амын 67 хувийг буюу 18-аас дээш насны нийт хүн амын 42 хувийг эзэлж байна.

Зураг 77: Орон нутгийн захиргааны шударга хандлага (салбараар)



Засгийн газрын түвшинд "шударга бус" хандах хүлээлт төрийн бус байгууллагын оролцогчдын 33.3 хувьтай харьцуулахад төрийн албан хаагчдын хувьд ердөө 7.1 хувь байна (Зураг 78). Төрийн үйлчилгээний салбарын оролцогчдын 14 хувь, хувийн хэвшлийн оролцогчдын 12.4 хувь "шударга бус" хандах хүлээлттэй байна.


Зураг 78: Төрийн захиргааны шударга хандлага (салбараар)




Шүүх тогтолцооны хувьд төрийн албан хаагчдын 16.7 хувь, хувийн болон төрийн бус байгууллагын судалгаанд оролцогчдын 23.3 хувь "шударга бус" хандах хүлээлттэй байна (Зураг 7.9). Үүнийн нэгэн адилаар төрийн үйлчилгээний салбараас судалгаанд оролцогчдын 21.2 хувь "шударга бус" хандах хүлээлттэй байна.

Хууль сахиулах байгууллагын шударга хандах хүлээлт нь ижил хандлагатай байсан. Төрийн албан хаагчдын ердөө 15.5 хувь "шударга бус" хандлагын хүлээлттэй байхад төрийн үйлчилгээний салбарын оролцогчид 17.6 хувь, хувийн хэвшил 22.6 хувь болон төрийн бус байгууллагад ажилтай оролцогчдын 26.7 хувь "шударга бус" хандлагын хүлээлттэй байна (Зураг 7.10).

Зураг 7.9 Шүүхийн тогтолцооны шударга хандлага (салбараар)



Зураг 7.10: Хууль сахиулах байгууллагын шударга хандлага (салбараар)




ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГА



8. ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГА

Энэ жилийн судалгаагаар Дээд түвшний авлигыг бүрдүүлэх хүчин зүйлүүдэд тодорхойлолтод их өөрчлөлт ажиглагдаагүй ч цаг хугацааны явцад зарим хэлбэлзэл гарсан байна. Жишээ нь 2012 болон 2016 оны сонгуулиар судалгаанд оролцогчдын дунджаас дээш хувь нь "Улс төрийн өндөр сонирхол бүхий хэргүүд"-ийг дурьдаж байсан (Зураг 8.1). 2015 болон 2016 онуудад судалгаанд оролцогчдын дунджаас дээш хувь нь "дотоод болон гадаадын том бизнесүүдийн оролцоотой хэргүүд"-ийг дурдсан. Цаг хугацааны явцад "Төрийн өндөр албан тушаалтнууд оролцсон тохиолдлууд" хамгийн бага өөрчлөлттэй байсан ба 2016 онд судалгаанд оролцогчдын 20.4 хувь үүнийг гэж үзсэн ДТА байна.


Зураг 8.1: Дээд түвшний авлига тодорхойлолт (зөвхөн хүчин төгөлдөр хариултууд: "хэлж мэдэхгүй/хариулаагүй" болон "бусад" гэсэн сонголтүүд ороогүй болно).



2014 оноос хойш дээд түвшний авлигын талаар тодорхой ойлголттой болсон иргэдийн тоо харьцангуй нэмэгдсэн. 2014 онд судалгаанд оролцогчдын 18.6 хувь нь дээд түвшний авлигын талаар мэдэхгүй эсвэл ямар нэгэн бодолгүй байсан бол энэ тоо буурсаар 2015 онд 11.8 хувь, 2016 онд ердөө 7.8 хувь болсон (Зураг 8.2).

2012 оны 11 дүгээр сараас хойш "Монгол улсад дээд түвшний авлига их байдаг" гэж хариулсан оролцогчдын тоо бага зэрэг хэлбэлзсэн хэдий ч өндөр хэвээр байна. 2012 оны 11 дүгээр сард 43.1 хувь байсан нь 2014 оны 3 дугаар сард 37.6 хувь буурсан ч 2016 оны 3 дугаар сард 43.1 хувь болж буцаж өсчээ. "Дээд түвшний авлигын зарим нэг тохиолдлууд байгаа" гэж үзэх оролцогчдын тоо тогтмол нэмэгдэж байна. 2012 оны 11 дүгээр сард 24 хувь байсан нь 2016 онд 35.4 хувь болж өсчээ.

Зураг 8.2: Монгол дахь дээд түвшний авлигын түвшин




Дээд түвшний авлига Монголд оршиж байгаа шалтгаан нь "Бизнес, улс төрийн сонирхол нийлсэн учраас" гэсэн хариулт 2016 онд 12 хувь болж нэмэгдсэн байна (Зураг 8.3). Энэ нь 2012 оны Улсын их хурлын сонгуулийн жилийн 11.2 хувьтай ойр байна. Бизнес болон улс төрийн сонирхол, зөрчилдөөн зэрэг нь сонгуулийн үеэр ил гардагтай холбоотой байж болох юм.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын томоохон компаниуд авлигын арга замыг ихээхэн ашигладаг гэж үзэх оролцогчдын тоо тогтвортой өссөөр 2012 оны 11 дүгээр сард 16.2 хувь байснаас 2016 оны 3 дугаар сард 20.4 хувь болжээ. Харин дотоодын томоохон компаниуд "Асуудлаа авлигаар шийдэх нь түгээмэл" гэж үзэх оролцогчдын тоо харьцангуй тогтвортой байгаа ба 2016 оны 3 дугаар сард 7.8 хувь байна. Асуудал шийдэгдэхгүй байгаагийн үндсэн шалтгааныг төр засгийн дээд түвшинд ил тод байдал хангалтгүй (17.9 хувь) мөн хууль эрх зүйн тогтолцоо ийм түвшний асуудлыг авч шийдэх чадваргүй байдаг (16.7 хувь) гэж судалгаанд оролцогчид үзжээ.


Монгол улсын эдийн засагт хяналт муутай их хэмжээний мөнгө байгаа гэж үзсэн оролцогчдын тоо бага зэрэг буурсан нь нийэм эдийн засгийн ерөнхий хямралтай холбоотой байж болох юм.

Зураг 8.3: Яагаад дээд түвшний авлига Монголд оршиж байна вэ?




Судалгаа хийгдсэн хугацааны туршид дунджаар оролцогчдын гуравны нэг нь ДТА хахуулийн хэмжээг мэднэ хэмээн хариулжээ. 2016 онд энэ тоо 33.8 хувь байна (Зураг 8.4). Оролцогчдын хариултыг бодитоор нь хэмжихэд их хэмжээний зөрүүтэй байна.

Зураг 8.4: Дээд түвшний авлигын хэмжээний талаарх төсөөлөл




2016 онд олон нийтийн дээд түвшний авлигын талаархи мэдээлэл авах нь буурсан байна. 16.5 хувь нь ДТА-ын талаар "байнга" олж сонсдог гэсэн бол судалгааны дундаж 20.6 хувь байна (Зураг 8.5). Энэ нь мөн л сонгуулийн улиралтай холбоотой байж магадгүй. Учир нь 2012 онд судалгаанд оролцогчдын 16.1 хувь дээд түвшний авлигын талаар "байнга" олж сонсдог гэж байсан ба дараагийн судалгаагаар энэ тоо өссөн. Хэвлэл мэдээллийн байг ууллагын зүгээс сонгуулийн үеэр түгээж буй мэдээлэл үүнд нөлөөлдөг байж болох юм.

Зураг 8.5: Дээд түвшний авлигын талаар олж сонсох



Дээд түвшний авлига ихэвчлэн ямар хэлбэрээр байдаг талаарх санал бодол 2012 оноос хойш мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй хэвээр байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь "бэлэн мөнгө" гэж хариулдаг. Дараагийн хамгийн түгээмэл нэрлэгдсэн хэлбэр нь "захиргааны албан тушаал" байсан (Зураг 8.6).


Зураг 8.6: Дээд түвшний авлигын хэлбэрийн чиг хандлага
(Олон сонголт хариулт - нийт хувь нь 100-аас их)



Цаг хугацааны явцад дээд түвшний айл өрхүүдэд үзүүлж буй үр нөлөөний талаар олон нийтийн санаа бодолд ихээхэн өөрчлөлт гарсан. Анх 2012 онд Монголын ард иргэдэд дээд түвшний авлига гэдэг ойлголтыг танилцуулж байхад нийт хүн амын 42.4 хувь ДТА-ын талаар ямар нэгэн үзэл бодолгүй эсвэл тухайн өрхөд үзүүлж буй нөлөөллийн талаар мэдэхгүй байсан юм (Зураг 8.7). Дараа жил нь энэ тоо 19.7 хувь болж буурч бага зэргийн хэлбэлзэлтэйгээр энэ хэмжээндээ үлдсэн. 2016 онд ямар нэгэн бодолгүй/мэдэхгүй гэж хариулсан оролцогчдын тоо 17.1 хувь болж буурсан. Амьжиргааны түвшин ихээхэн муудсан байгаа ч хүн амын томоохон хэсэг нь одоог хүртэл өндөр түвшний авлигын нөлөөг мэдэхгүй, уялдаа холбоог нь ойлгож чадахгүй байна (СМС Politbarometer судалгааны мэдээлснээр, 2012-2016 он).


Дээд түвшний авлига тухайн өрхөд ямар ч нөлөө үзүүл дэггүй гэж хариулах оролцогчдын тоо өмнөх судалгаагаар бага зэрэг хэлбэлзэж байсан ба зөвхөн 2013 оны 3 дугаар сараас хойш нэмэгдэж байна. 2015 оны 3 дугаар сар болон 2016 оны 3 дугаар сард судалгаанд оролцогчдын дөрөвний нэг орчим нь ДТА ямар ч нөлөө үзүүлдэггүй гэж үзсэн (тус тус 23.8 хувь ба 24.9 хувь).

Зураг 8.7: Дээд түвшний авлигын өрхүүдэд үзүүлэх нөлөө




Олон нийтийн хувьд ДТА-тай тэмцэх тэргүүний сонголт АТГ хэвээр байна. АТГ гэсэн сонголт 2014 онд 35.7 хувиас 2015 онд 30.8 хувь болж буурсан хэдий ч 2016 онд буцаж 36.6 хувь болсон байна (Зураг 8.8). Дээд түвшний авлигатай тэмцэх ажлыг Засгийн газар удирдан зохион байгуулах ёстой гэж үзэх судалгаанд оролцогчдын тоо сүүлийн гурван жилд тогтвортой бүүрсаар байна. 2014 онд 26.2 хувь, 2015 онд 20.4 хувь ба 2016 онд 17.3 хувь болжээ.

Зураг 8.8: Дээд түвшний авлигатай тэмцэх ажлыг удирдах байгууллага



ДТА-ын өрхийн амьдралд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн талаар асуухад судалгаанд оролцогчдын гуравны нэг нь "амьжиргааны түвшин буурч байна" гэж хариулсан (Зураг 8.9). Судалгаа хийгдсэн хугацааны туршид судалгаанд оролцогчдын ойролцоогоор дөрөвний нэг нь үнийн өсөлтийг тэмдэглэсэн (23.0 хувь) бол тавны нэг нь хүнд суртал болон ил тод бус байдлыг онцолж байна (19.2 хувь). Дээд түвшний авлига гэр бүлийн бизнест сөргөөр нөлөөлж байна гэж үзэх судалгаанд оролцогчдын тоо бага багаар нэмэгдсээр байна. Энэ тоо нь 2013 оны 3 дугаар сард 4.5 хувь байсан бол 2016 оны 3 дугаар сард 11.8 хувь болж хоёр дахин нэмэгджээ.

Зураг 8.9: Дээд түвшний авлига өрхүүдэд үзүүлэх нөлөө



Авлигатай тэмцэх хамгийн үр дүнтэй аргуудын талаар асуухад судалгаанд оролцогчид "Авлигатай тэмцэх хууль эрх зүйг боловсронгуй болгох" нь хамгийн үр дүнтэй гэж үзжээ (Зураг 8.10). Энэ нь олон нийт одоо байгаа хууль тогтоомж дээд түвшний авлигыг арилгахад хангалтгүй гэж үздэгийг илтгэж байна. Хууль сахиулах байгууллагын эрх мэдлийг нэмэгдүүлэх арга хэмжээ нь хоёр дахь хамгийн түгээмэл сонголт байсан. Авлигын эсрэг хүчтэй бодлого хэрэгжүүлэх улс төрийн намууд болон бие даасан хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дэмжих арга хэмжээг багатай байна гэж үзсэн.

Зураг 8.10: Дээд түвшний авлигатай тэмцэх хамгийн үр дүнтэй арга
(олон сонголт – зөвхөн хүчин төгөлдөр хариулт)




ӨРХИЙН ТҮВШНИЙ АВЛИГА



9. ӨРХИЙН ТҮВШНИЙ АВЛИГА


2010 оны 3 дугаар сараас хойш хээл хахууль төлөхөөс татгалзана гэж хариулсан оролцогчдын тоо аажмаар нэмэгдсээр байна. 2016 судалгаагаар энэ тоо нь хамгийн өндөрт хүрч оролцогчдын 45.1 хувь хахууль төлөхөөс татгалзана гэж хариулжээ (Зураг 9.1). Түүнчлэн мөнгө байвал хахууль өгнө гэж хариулах оролцогчдын тоо буурсаар 2016 оны 3 дугаар сард 18.6 хувьтай байна. Гэсэн хэдий ч хахууль нэхсэн тохиолдолд авлигын талаар мэдээлэх иргэдийн тоо буурч 2016 оны 3 дугаар сард дөнгөж 13.6 хувьтай байна.

Зураг 9.1: Хээл хахууль нэхсэн тохиолдолд үзүүлэх хариу үйлдэл




Хээл хахуулийг хаана мэдэгдэх вэ? гэсэн асуултанд судалгаанд оролцогчид тухайн байгууллагын удирдлагыг илүүтэйгээр сонгож байна. 2015 онд судалгаанд оролцогчдын 50 хувь нь хээл хахууль нэхсэн тохиолдолд АТГ-т мэдэгдэх болно гэж хариулж байсан боловч сүүлийн судалгаанд ердөө 40.4 хувь л АТГ-ыг сонгосон. Харин удирдлагад мэдэгдэнэ гэж хариулсан оролцогчдын тоо ижил хугацаанд 22.6 хувиас 31.9 хувь болж өсчээ (Зураг 9.2).

Зураг 9.2: Авлигын талаар хаана мэдэгдэх вэ?




Байгууллагууд үйл ажиллагаандаа "хандив" авах тохиолдол нэлээд гардаг байгаа. Эдгээр "хандив" нь мөнгө босгох, засвар хийх гэх мэт төрөл бүрийн зориулалттай байсан бөгөөд хандивын хэмжээ хэдэн мянгаас хэдэн сая төгрөг хүртэл байна. Олон нийт эдгээр "хандив" нь хээл хахуулийн нэг хэлбэр мөн эсэх талаар өөр өөр санал бодолтой байна. Ойролцоогоор тал нь (46 хувь) хандивийг авлига, хээл хахуулийн нэг хэлбэр болсон гэж үзэж байхад үлдсэн тал нь (43 хувь) үүнийг байгууллагын үйл ажиллагаа дэмжих арга зам авч явах хууль ёсны арга зам гэж харж байна (Зураг 9.3).

Зураг 9.3: Хандив - хээл хахууль эсвэл байгууллагыг дэмжих нэг арга зам?




2013 оны 3 дугаар сард өрхийн түвшний хээл хахуулийн талаарх өрхүүдийн мэдээлэл 10 хувиас доош оржээ (Зураг 9.4). 2013 онд өрхүүдийн 9 орчим хувь сүүлийн гурван сарын хугацаанд хахууль өгсөн хэмээн хариулж байсан бол 2015 онд энэ тоо 7 хувь болж буурсан бөгөөд 2016 оны судалгаанд энэ тоо хэвээр байна.

Зураг 9.4: Өрхийн түвшний хээл хахуулийн байдал



Хүртэх ёстой үйлчилгээгээ авахын тулд хахууль өгсөн гэж мэдээлэх иргэдийн хувь хэмжээ нэмэгдсээр 2012 оны 55.6 хувиас 2016 онд 72.5 хувь болж өссөн (Зураг 9.5). Харин хахууль шууд нэхсэн тохиолдол 2016 онд 8 хувь болж буурчээ.

Зураг 9.5: Сүүлийн 3 сарын хугацаанд хахууль өгөх болсон гол шалтгаан юу байсан бэ?



Сүүлийн судалгаагаар хээл хахууль гэр бүлд нь ноцтой хохирол учруулсан гэж мэдээлэх оролцогчдын тоо ижил хэвээр байна. 2015 болон 2016 онуудад судалгаанд оролцогчдын дөрөвний нэг орчим нь хахуульд өгсөн мөнгө гэр бүлийн төсөвт "Ноцтой хохирол" учруулдаг гэж хариулжээ (Зураг 9.6). Энэ хугацаанд дундаж хахуулийн хэмжээ 277 сая төгрөгөөс 336 сая төгрөг болж нэмэгдэж Монголын өрхүүдийн хээл хахуульд зарцуулсан нийт мөнгөний хэмжээ 14.9 тэрбум төгрөгөөс 18.5 тэрбум төгрөг болж өсчээ (Хүснэгт 9.1).

Зураг 9.6: Хээл хахууль өрхийн төсөвт "ноцтой" хохирол үзүүлсэн байдал



Хүснэгт 3: Өрхийн түвшний хээл хахуулийн статистик мэдээ

	Дундаж хээл хахууль (1000₮-р)	Хахууль өгсөн өрхийн хувийн жин	Төлсөн нийт дүн (тэр бум ₮)	Өрхийн тоо (мянгаар)	Статистикийн эмхтгэл
03.2006	181	26%	28.8	611	2005
09.2006	136	28%	23.3	611	2005
03.2007	102	23%	14.8	632,5	2006
09.2007	187	22%	26	632,5	2006
03.2008	180	19%	23.2	645,7	2007
09.2008	298	21%	424	645,7	2007
03.2009	397	15%	40.3	677,8	2008
09.2009	308	20%	41.7	677,8	2008
03.2010	195	16%	21.2	677,8	2008
09.2010	416	13%	38.8	717	2009
04.2011	319	8.80%	20.8	742	2010
11.2012	391	1240%	35.9	742	2010
03.2013	502	8.75%	32.6	742	2010
09.2013	525	7.64%	30.8	768,3	2012
03.2014	520	7.57%	30.2	768,3	2012
04.2015	277	6.77%	14.9	794	2013
03.2016	336	6.70%	18.5	8234	2014

СУДАЛГААНД АШИГЛАСАН АСУУЛГА

Авлигын талаарх олон нийтийн ойлголт болон мэдлэг тогтоох судалгааны үндсэн зорилго нь Монгол улс дахь авлигын түвшинг тодорхойлоход оршино. Бид улс орон даяар 1360 гаруй хүнээс энэхүү судалгааг авч байгаа юм. Бид янз бүрийн авлигын хэлбэр болон танд тохиолдож болох өдөр тутмын авлигын талаарх таны мэдлэг туршлага, санал бодлыг судлах болно.

Таны хэрхэн хариулсаныг хэн нэгэн мэдэх боломжгүй гэдэгт Та итгэлтэй байж болно. Санал асуулгад сайн дурын үндсэн дээр оролцох бөгөөд бүх хариултын хувьд тодорхой зээг заахгүйгээр мэдээллийн нууцыг хадгална.

Энэхүү судалгааг амжилттай явуулахад таныг хамтран ажилласанд гүн талархал илэрхийлье. Хэрэв манай судалгаатай холбогдсон ямар нэг асуудал гарвал манай албаны 70116373 тоот утсаар лавлах боломж Танд байна. Судалгааны үр дүнг олон нийтэд өргөнөөр танилцуулах болно.

А. Ерөнхий хэсэг

1. Таны бодлоор манай улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн хувьд өнөөдөр т үлгамдаж буй хамгийн чухал асуудал юу вэ?

2. Зарим хүмүүс авлига Монголын нийгмийн амьдралын янз бүрийн хүрээнд нөлөөлж байна гэж үздэг. Таны бодлоор авлига ... хүрээнд огт нөлөөлдөггүй, бага зэрэг, тодорхой хэмжээгээр, их хэмжээгээр нөлөөлдөг вэ?

Хүрээ	Огт нөлөөлдөггүй	Бага зэрэг нөлөөлдөг	Тодорхой хэмжээгээр нөлөөлдөг	Их хэмжээгээр нөлөөлдөг	Хэлж мэдэхгүй/Хариулаа-гүй
2.1 Таны хувийн болон гэр бүлийн амьдралд	1	2	3	4	9
2.2 Бизнесийн хүрээнд	1	2	3	4	9
2.3 Улс төрийн амьдралд	1	2	3	4	9

3. 2016-2017 онуудад хэд хэдэн сонгууль болох гэж байна. Ер нь сонгуультай холбоотой үйл ажиллагаанууд хэр зэрэг ил тод шударга явж байна гэж та бодож байна вэ?

		ОГТ ҮГҮЙ	ТИЙМ, Бага зэрэг	ТИЙМ, Тодорхой хэмжээгээр	ТИЙМ, Их хэмжээгээр	Мэдэхгүй/Хариулаа-гүй
3.1	Сонгуулийн бэлтгэл, Жишээ нь: сонгогчдыг бүртгэх, сонгуулийн хороод болон ажилтнуудыг бэлтгэх, гадаад дотоодын ажиглагчдыг оролцуулах гэх мэт	1	2	3	4	9
3.2	Сонгуулийн санхүүжилт	1	2	3	4	9
3.3	Сонгуулийн сурталчилгааны үе/сонгуулийн кампани/	1	2	3	4	9
3.4	Санал хураалт	1	2	3	4	9
3.5	СЭХ-ноос сонгуулийн дүнг нэгтгэж олон нийтэд танилцуулах үе	1	2	3	4	9

4. Доор дурдсан байр суурьтай Таны бодол хэр зэрэг нийцдэг вэ?

	Нийцдэг	Бага зэрэг нийцдэг	Төдийлөн нийцдэггүй	Нийцдэггүй	Хэлж М-гүй /Х-гүй
4.2 Өнөөгийн улс төрийн тогтолцоо авлигыг зогсоохын тулд амжилттай тэмцэж байна.	1	2	3	4	9
4.3а. Иргэний нийгэм авлигыг урьдчилан сэргийлж чадна.	1	2	3	4	9
4.3б. Зөвхөн төрийн байгууллагууд авлигыг урьдчилан сэргийлэхэд тусалж чадна.	1	2	3	4	9
4.4 Өнөөгийн нөхцөлд иргэдийн хөдөлгөөн, төрийн бус байгууллагууд авлигын эсрэг тэмцэх гол хүчин юм.	1	2	3	4	9
4.5 Улс төрчид авлигаас тодорхой ашиг хонжоо олдог учраас бодит хэрэг дээрээ авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл байдаггүй.	1	2	3	4	9
4.6 Нийгэмд газар авсан хүнд суртлыг гэтлэн давах цорын ганц арга нь хээл хахууль өгөх явдал юм.	1	2	3	4	9
4.7 Авлигаас болж том бизнесийнхэнээс илүүтэйгээр жижиг, дунд бизнес эрхлэгчид хохирдог.	1	2	3	4	9
4.8 Авлига тодорхой хэмжээнд байхыг хүлээн зөвшөөрнө.	1	2	3	4	9
4.9 Том бизнес авлигын гол эх үүсвэрийн нэг нь.	1	2	3	4	9
4.10 Хээл хахууль нь зарим үед шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг.	1	2	3	4	9
4.11 Орон нутгийн захиргааны албан хаагчид ихэнхдээ итгэл үзүүлж болохуйц хариуцлагатай хүмүүс байдаг.	1	2	3	4	9
4.12 Авлигыг багасгахад иргэд өөрсдөө хариуцлагатай байх ёстой.	1	2	3	4	9
4.13 Авлигын эсрэг өнөөгийн хууль үрдүнтэйгээр хэрэгжихгүй байна.	1	2	3	4	9
4.14 Шийдвэр гаргагчид өөрсдөө авлигаас төдийлөн хохирдоггүй, жирийн иргэд авлигын дарамтыг илүү мэдэрч байгаа.	1	2	3	4	9
4.15 Төрийн албан хаагчид бага цалин авч байгаа нь хээл хахуулийн нэг гол шалтгаан болдог.	1	2	3	4	9
4.16 Албан тушаалтнуудад хатуу ял шийтгэл оногдуулах нь авлигыг зогсооно.	1	2	3	4	9
4.17 Авлига тодорхой түвшинд цаашид байсаар байх болно	1	2	3	4	9
4.18 Хээл хахууль өгсөн хүн түүнийг авсан хүнтэй адил гэм буруутай.	1	2	3	4	9
4.19 Авлигатай тэмцэх бодлогын хэрэгжүүлэлт улс төрийн сонирхол агуулаагүй.	1	2	3	4	9

5.	Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?	Ихээхэн өссөн	1.
		Бага зэрэг өссөн	2.
		Хэвээр үлдсэн	3.
		Бага зэрэг буурсан	4.
		Ихээхэн буурсан	5.
		Хэлж мэдэхгүй/Хариулаагүй	9.

6.	Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ?	Ихээхэн өснө	1.
		Бага зэрэг өснө	2.
		Хэвээр үлдэнэ	3.
		Бага зэрэг буурна	4.
		Ихээхэн буурна	5.
		Хэлж мэдэхгүй/Хариулаагүй	9.

В хэсэг. Авлигатай тэмцэх

7.	Авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (1 сонголт хийнэ)	Засгийн газар	1.
		Орон нутгийн засаг захиргаа	2.
		Хууль сахиулах байгууллага	3.
		Иргэд (иргэдийн хөдөлгөөн)	4.
		Улсын Их Хурал	5.
		Шүүхийн байгууллагууд	6.
		Төрийн бус байгууллагууд	7.
		Ерөнхийлөгч	8.
		Авлигатай тэмцэх газар	9.
		Хууль зүйн яам	10.
		Хувийн хэвшил	11.
		Бусад (тодорхой бичих):	12.

8.	Таны бодлоор одоогийн Засгийн газар (Ерөнхий сайд Сайханбилэг тэргүүлж буй) өмнөх Засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ?	Авлигын асуудлыг илүү сайн шийдвэрлэж байна	1.
		Өмнөх тэйгээ адил байна	2.
		Өмнөхөөсөө дор байна	3.
		Хэлж мэдэхгүй/Хариулаагүй	9.

9. Авлигатай тэмцэхэд доорх хүчин зүйлсүүд саад тотгор болдог уу?

	Огт үгүй	Бага зэрэг	Тодорхой хэмнээгээр	Их хэмнээгээр	Хэлж м-гүй / Х-гүй
9.1 Төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үр чадвар муу	1	2	3	4	9
9.2 Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад <u>улс орны</u> түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй	1	2	3	4	9
9.3 Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад <u>орон нутгийн</u> түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй	1	2	3	4	9
9.4 Хүндрэлтэй асуудлыг хууль дүрмийн дагуу бус хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл болсон	1	2	3	4	9
9.5 Хууль сахиулах байгууллагын хүрээнд авлига газар авсан	1	2	3	4	9
9.6 Олон нийтийн идэвхгүй байдал	1	2	3	4	9
9.7 Авлигатай тэмцэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, хүлээлгэх ял шийтгэл нь боловсронгуй биш	1	2	3	4	9

10. Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх ёстой вэ? (1 сонголт хийнэ)	Хүчтэй арга хэмжээ авах, хатуу шийтгэл оногдуулах	1.
	Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх	2.
	Засаг захиргааны шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, ил тод болгох	3.
	Төрийн зүгээс захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгох	4.
	Иргэд, төрийн бус байгууллагуудын зүгээс төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгох	5.
	Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх	6.
	Хуулиа тогтвортой хэрэгжүүлэх	7.
	Бусад (тодорхой бичих)	8.

11.	2006 онд Авлигын эсрэг шинэ хууль батлагдсан. Та шинэ хуулийн хүрээнд аль нэг албан тугшаалтан шийтгүүлсэн тухай сонссон уу?	Тийм	1.
		Үгүй	2.

12.	Авлигатай Тэмцэх газарт авлигын талаар мэдүүлэх утас ажиллаж байгааг та мэдэх үү?	Тийм	1.
		Үгүй	2.

13.	Хэрвээ Авлигатай Тэмцэх газар нэр хаяггүй мэдээлэл хүлээж авна гэвэл Та авлигын талаар мэдээлэл өгөх үү?	Тийм	1.
		Үгүй	2.
		Мэдэхгүй / Хариулаагүй	3.

С хэсэг. Байгууллагууд

14.	Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг Та хэрхэн үнэлж байна вэ?	Их сайн	1.
		Харьцангуй сайн	2.
		Сайн ч биш, муу ч биш	3.
		Тааруухан	4.
		Муу	5.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	9.

15.	Авлигатай тэмцэх газарт Та хэр зэрэг итгэдэг вэ?	Их итгэдэг	1.
		Итгэдэг	2.
		Бараг итгэдэггүй	3.
		Огт итгэдэггүй	4.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	5.

16.	Та Авлигатай тэмцэх газар бие даасан, аль нэг улс төрийн хүчнээс хамааралгүй үйл ажиллагаа явуулж чаддагт итгэдэг үү?	Тийм	1.
		Үгүй	2.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	3.

17. Манай улсын нийгэм, эдийн засгийн доорх салбаруудад авлига хэр зэрэг тархсан гэж Та боддог вэ?

Авлигад автагдсан байдал Салбарууд	Огтгүй	Бага зэрэг	Тодорхой хэмнээг-ээр	Нилээд хэмнээг-ээр	Маш ихээр	Хэлж мэдэхгүй /Х-гүй
17.1 Гааль	1	2	3	4	5	9
17.2 Боловсролын тогтолцоо	1	2	3	4	5	9
17.3 Эрүүл мэндийн тогтолцоо	1	2	3	4	5	9
17.4 Шүүхийн тогтолцоо	1	2	3	4	5	9
17.5 Хууль сахиулах байгууллага	1	2	3	4	5	9
17.6 Улс төрийн намууд	1	2	3	4	5	9
17.7 Хууль тогтоох байгууллага /Улсын Их Хурал/	1	2	3	4	5	9
17.8 Засгийн газар	1	2	3	4	5	9
17.9 Орон нутгийн засаг захиргаа	1	2	3	4	5	9
17.10 Бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлдэг албад (төрснийг, гэр бүл болсныг иргэний журмаар бүртгэх, лиценз, зөвшөөрөл олгох)	1	2	3	4	5	9
17.11 Татварын алба	1	2	3	4	5	9
17.12 Уул уурхайн салбар	1	2	3	4	5	9
17.13 Газрын асуудал эрхэлсэн албад	1	2	3	4	5	9
17.14 Мэргэжлийн хяналтын газар	1	2	3	4	5	9
17.15 Орон нутгийн ханган нийлүүлэх тендерууд	1	2	3	4	5	9
17.16 Банк, санхүүгийн байгууллагууд	1	2	3	4	5	9

18.	Та өөр авлига өргөн тархсан байгууллага нэрлэж чадах уу?	
-----	----------------------------------------------------------	--

D хэсэг. Хувийн туршлага

19.	Хэрэв төрийн албан хаагч эсвэл хувийн байгууллагын ажилтан Танаас шууд хахууль нэхвэл Та яах вэ? (гол нэгийг сонгоно уу)	Би хээл хахууль өгөхгүй	1.
		Аль нэг газарт мэдэгдэх болно (асуулт 20-ийг хариулна)	2.
		Мөнгө байвал хахууль өгнө	3.
		Хахууль өгөлгүйгээр асуудлыг шийдвэрлэхэд туслах хэн нэгнийг хайх болно	4.
		Би юу ч хийлгүй нөхцөл байдал өөрчлөгдөхийг хүлээх болно.	5.
		Мэдэхгүй/Хариулаагүй	9.

Хэрвээ аль нэг газарт мэдэгдэх болвол

20.	Хэрвээ мэдэгдэх болвол хаана? (гол нэгийг сонгоно уу)	Удирдлага /тухайн байгууллагын/	1.
		Авлигатай тэмцэх газар	2.
		Цагдаа	3.
		Хэвлэл мэдээлэл	4.
		ЗГ-ын 11-11 утас	5.
		Өөр	6.

БҮХ ХҮНЭЭС АСУУНА

21.	Авлигын талаарх голлох мэдээллээ Та аль эх сурвалжаас авдаг вэ? (гол нэгийг сонгоно уу)	ТВ (асуулт 22-г хариулна)	1.
		Сонин, хэвлэл	2.
		Интернет, Social Media /форум, блог/ (асуулт 23-г хариулна)	3.
		Радио	4.
		Өөрт тохиолдсон туршлагаас	5.
		Найз нөхөд, хамаатан садан	6.
		Ам дамжсан яриа	7.
		Бусад эх сурвалж (тодорхой бичих):	8.

Хэрвээ А21-д ТВ сонгосон бол

22.	Авлигын талаар хамгийн их мэдээлдэг сувгийг нэрлэнэ үү? (гол нэгийг нэрлэнэ үү)	
-----	------------------------------------------------------------------------------------	--

Хэрвээ А21-д Интернет, Social Media /веб, форум, блог/ сонгосон бол

23.	Авлигын талаар хамгийн их мэдээлэл дамждаг хэрэгсэл /сайт/-ийг нэрлэнэ үү? (гол нэгийг нэрлэнэ үү)	Фейсбук /Facebook/	1.
		Твиттер /Twitter/	2.
		Мэдээллийн сайтүүд	3.
		Өөр(тодорхой бичих):	4.

Одоо дараагийн асуудал руу шилжье.

24. Та доорх салбаруудад үйлчлүүлэх болвол тантай хэр зэрэг шударга харьцана гэж бодож байна вэ?

Салбарууд	Шударга бус	Бага зэрэг	Харьцан-гүй	Шударга	М-гүй /Х-гүй
1. Боловсролын салбар	1	2	3	4	9
2. Эрүүл мэнд	1	2	3	4	9
3. Шүүхийн тогтолцоо	1	2	3	4	9
4. Хууль сахиулах байгууллага	1	2	3	4	9
5. Орон нутгийн захиргаа	1	2	3	4	9
6. Төрийн захиргаа	1	2	3	4	9

25.	Та сонирхолын зөрчлийн хууль батлагдсаныг мэдэх үү?	Тийм	1.
		Үгүй	2.

26.	Хэрвээ Та ашиг сонирхолын зөрчлийн талаар мэдвэл аль нэг газарт мэдэгдэх үү?	Тийм (асуулт 27-г хариулна)	1.
		Үгүй (асуулт 28-рүү шилжинэ)	2.

27.	Хэрвээ мэдэгдэх болвол хаана? (гол нэгийг сонгоно уу)	Удирдлага /тухайн байгууллагын/	1.
		Авлигатай тэмцэх газар	2.
		Цагдаа	3.
		Хэвлэл мэдээлэл	4.
		ЗГ-ын 11-11 утас	5.
		Өөр	6.

27. Хэрвээ мэдэгдэх болвол хаана? (гол нэгийг сонгоно уу)	Удирдлага /түхэйн байгууллагын/	1.
	Авлигатай тэмцэх газар	2.
	Цагдаа	3.
	Хэвлэл мэдээлэл	4.
	ЗГ-ын 11-11 утас	5.
	Өөр	6.

28_add. Энэ цаг үеээс сургууль, цэцэрлэг гэх мэт олон байгууллагууд иргэдээс хандивын нэрээр шууд мөнгө нэхэж авдаг. Зарим хүмүүс хан дивыг авлига/хээль хахуулийн бас нэг өөр хэлбэр гэж боддог, зарим нь байгууллагын төсвийг бүрдүүлэх нэг арга зам гэж боддог. Таны бодлоор

- Энэ нь илүү авлига/хээль хахуулийн нэг хэлбэр	1.
- Энэ нь илүү байгууллагын төсвийг авч явах нэг хэлбэр	2.
- Мэдэхгүй/хариулаагүй	9.

29. Сүүлийн 3 сарын хугацаанд Таны болон танай гэр бүлийн гишүүдийн зүгээс ямар нэгэн хэлбэрээр хээл хахууль өгсөн үү?	Тийм	1.
	Үгүй Е хэсэг рүү шилжинэ	2.
	Мэдэхгүй Е хэсэг рүү шилжинэ	3.
	Татгалзсан Е хэсэг рүү шилжинэ	4.

	30. Сүүлийн 3 сарын хугацаанд Та хэнд хахууль өгсөн бэ? (олон сонголттой)	31. Хэрвээ өгсөн бол ойролцоогоор хэдийг өгсөн бэ?
1.	Багшид	
2.	Эрүүл мэндийн салбарын ажилтанд	
3.	Төрийн захиргааны байгууллагын ажилтанд	
4.	Цагдаагийн ажилтанд	
5.	Шүүгчид	
6.	Өмгөөлөгч/хуульчид	
7.	Прокурорт	
8.	Татварын байцаагчид	
9.	Нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтанд	
10.	Гаалийн байцаагчид	
11.	Орон нутгийн захиргааны ажилтанд	
12.	Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд /сонин, телевиз, радио/	
13.	Бусад (тодорхой бичих):	

32.	Таны хахуульд өгсөн мөнгөний нийт дүн Танай өрхийн төсөвт хэр зэрэг нөлөөлсөн бэ?	Огт нөлөөлөөгүй	1.
		Бага зэрэг	2.
		Тодорхой хэмжээгээр	3.
		Нилээд	4.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	5.

33.	Таны хахууль өгөх болсон гол шалтгаан юу байсан бэ? (гол нэгийг сонгоно уу)	Хахуулийг шууд нэхсэн	1.
		Эрх мэдэлтнүүдтэй холбогдож хүндрэлд орохгүйн тулд хахууль өгсөн	2.
		Хүртэх ёстой үйлчилгээгээ авахын тулд хахууль өгсөн	3.
		Аль нь ч биш	4.

Е хэсэг. Төр засгийн ил тод байдал

34. Төр засгийн үйл ажиллагааны ил тод байдал болон үр дүнт байдлыг дээшлүүлэхэд дараах арга хэмжээнүүд хэр ЧУХАЛ гэж та бодож байна вэ?

		Огтгүй	Бага зэрэг	Тодорхой хэмжээнд	Нилээд их	Маш их	М-гүй / Х-гүй
1	Шилэн дансны хууль	1	2	3	4	5	9
2	Бүртгэлийн цахим машин, нэг цонхны үйлчилгээ гэх мэт шинэ технологиууд	1	2	3	4	5	9
3	Төрийн албан хаагчдаас тогтмол гаргуулж авдаг орлогын мэдүүлэг	1	2	3	4	5	9
4	Шинэ сонгуулийн хууль	1	2	3	4	5	9
5	Өршөөлийн хууль	1	2	3	4	5	9

35. Төр засгийн үйл ажиллагааны үр дүнт болон ил тод байдлыг сайжруулах зорилгоор авч байгаа арга хэмжээнүүдийг хэр зэрэг ҮР ДҮНТЭЙ байна гэж та бодож байна вэ?

		Огтгүй	Бага зэрэг	Тодорхой хэмжээнд	Нилээд их	Маш их	М-гүй / Х-гүй
1	Шилэн дансны хууль	1	2	3	4	5	9
2	Бүртгэлийн цахим машин, нэг цонхны үйлчилгээ гэх мэт шинэ технологиууд	1	2	3	4	5	9
3	Төрийн албан хаагчдаас тогтмол гаргуулж авдаг орлогын мэдүүлэг	1	2	3	4	5	9
4	Шинэ сонгуулийн хууль	1	2	3	4	5	9
5	Өршөөлийн хууль	1	2	3	4	5	9

36. Өршөөлийн болон Ил тод байдлын тухай хуулиудыг хэрэгжүүлснээр Монголын далд эдийн засгийн томоохон нэг хэсэг нь торгууль, шийтгэлгүй албан ёсоор хуульчлагдсан.

Таны бодлоор энэ үйл явц нь ...

а.	Хувийн хэвшил дэх авлигын хэмжээг бууруулах үү?	Тийм	1.
		Үгүй	2.
		Мэдэхгүй / Хариулаагүй	3.

б.	Нийгэмд дургүйцэл төрүүлэх үү?	Тийм	1.
		Үгүй	2.
		Мэдэхгүй / Хариулаагүй	3.

F хэсэг. Дээд түвшний буюу Их авлига

38.	Та Их /дээд түвшний/ авлигыг юу гэж ойлгож байна вэ?	Бизнес, улс төрийн бүлэглүүдийн сонирхол бүхий	1.
		Төрийн өндөр албан тушаалтнууд оролцсон	2.
		Гадаадын болон дотоодын том бизнесийн оролцоотой авлига	3.
		Улс оронд их хэмжээний хохирол учруулсан	4.
		Зохион байгуулалттай бүлэглэл, сүлжээний оролцоотой	5.
		Авлигын хэмжээ маш их	6.
		Бусад (тодруулна үү):	7.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	9.

39.	Таны бодлоор Их /дээд түвшний/ авлига Монголд ямар түвшинд байна вэ?	Их хэмжээтэй	1.
		Зарим нэг тохиолдол бий	2.
		Цөөн хэдэн тохиолдол бий	3.
		Их авлига Монголд байхгүй	4.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	5.

40.	Таны бодлоор яагаад дээд түвшний авлига оршиж байна вэ?	Монгол улсын хууль эрх зүйн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, ийм түвшний асуудлыг авч шийдэж чадахгүй учраас	1.
		Монголын эдийн засаг т бараг хяналтгүй их хэмжээний мөнгө байгаа учраас	2.
		Төр засгийн дээд түвшинд ил тод байдал хангалтгүй учраас	3.
		Монголд үйл ажиллагаа явуулдаг гадны том компаниуд асуудлаа авилгалаар шийддэг түгээмэл практик бий болсон учраас	4.
		Монголын том компаниуд асуудлаа авилгалаар шийддэг түгээмэл практик бий болсон учраас	5.
		Бизнес, улс төрийн сонирхол нийлсэн учраас	6.
		Бусад (тодруулна уу):	7.
		Хэлж мэдэхгүй / Хариулаагүй	9.

41.	Танд дээд түвшний авлигын хэмжээний талаар төсөөлөл байна уу?	Тийм	1.
		Үгүй	2.
		Мэдэхгүй / Хариулаагүй	3.

42.	Та дээд түвшний авлигын талаар хэр их олж сонсдог вэ?	Байнга	1.
		Хааяа	2.
		Хэзээ ч үгүй (Q44-руу шилжинэ)	3.
		Мэдэхгүй/Хариулаагүй (Q44-руу шилжинэ)	4.

Хэрвээ сонссон бол

43.	Хэрэв сонссон бол ямар хэлбэрийн авлига байсан бэ? (Хэдийг ч сонгож болно)	Бэлэн мөнгө	1.
		Том хэмжээний бэлэг /байр, машин гэх мэт/	2.
		Бизнесийн түншлэл буюу хувьцаа	3.
		Гадаадад аялуулах	4.
		Албан тушаал	5.
		Өөр (тодруулна уу):	6.

44.	Дээд түвшиний авлига Таны болон танай гэр бүлийн амьдралд хэр нөлөөлдөг вэ?	Маш их	1.
		Тодорхой хэмжээнд	2.
		Бага хэмжээнд	3.
		Огт үгүй (Q46-руу шилжинэ)	4.
		Мэдэхгүй/Хариулаагүй (Q46-руу шилжинэ)	5.

45.	Хэрвээ дээд түвшиний авлига Таны болон танай гэр бүлийн амьдралд сөргөөр нөлөөлдөг бол ямар байдлаар гэдгийг тодорхой хэлнэ үү? (1 сонголт хийнэ)	Амьжиргааны түвшин буурж байна	1.
		Гэр бүлийн бизнес муудаж байна	2.
		Хүнд суртал, ил тод байдал ду тагдалтай байна	3.
		Төрийн үйлчилгээ хангалтгүй	4.
		Үний өсөлтөд нөлөөлж байна	5.
		Байгаль орчинд нөлөөлж байна	6.
		Өөр (тодруулна уу):	7.
		Мэдэхгүй/Хариулаагүй	9.

БҮХ ХҮНЭЭС АСУУНА

46.	Дээд түвшиний авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (1 сонголт хийнэ)	Засгийн газар	1.
		Орон нутгийн засаг захиргаа	2.
		Хууль сахиулах байгууллага	3.
		Иргэд (иргэдийн хөдөлгөөн)	4.
		Улсын Их Хурал	5.
		Шүүхийн байгууллагууд	6.
		Төрийн бус байгууллагууд	7.
		Ерөнхийлөгч	8.
		Авлигатай тэмцэх газар	9.
		Хууль зүйн яам	10.
		Хувийн хэвшил	11.
		Бусад (тодорхой бичих):	12.

47. Дээд түвшний авлигатай тэмцэхэд дараах арга хэмжээнүүдийн аль нь хамгийн их үр дүнтэй гэж та бодож байна вэ? (хоёр хүртэл хариулт сонгож болно).

1	Хууль сахиулах байгууллагад илүү их эрх мэдэл олгох
2	Орлогын мэдүүлгээ худлаа бөглөсөн тохиолдолд илүү хатуу хариуцлага тооцох
3	Иргэний байгууллагуудын оролцоо, чадавхийг сайжруулах
4	Авлигатай тэмцэх хууль эрх зүйг боловсронгуй болгох
5	Авлигатай тэмцэх ёс суртахууныг нэмэгдүүлэхэд анхаарах
6	Бие даасан хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дэмжих
7	Авлигалын эсрэг чанга хөтөлбөртэй улс төрийн намуудыг дэмжих

Судалгаанд оролцогчдын нийгэм, эдийн засгийн байдлын талаарх мэдээлэл:

<p>1. Төрсөн он: 19 _____</p> <p>2. Хүйс: Эр 1 Эм 2</p> <p>3. Боловсрол: · Үгүй 1 · Бага/бүрэн бус дунд 2 · Бүрэн дунд 3 · Тусгай дунд 4 · Дээд 5</p>	<p>4. Ажил (аль нэгийг нь сонгоно уу) · Үндсэн ажил 1 · Гэрээт буюу цагийн ажил 2 · Мэргэжлийн дадлага 3 · Ажилгүй 4 · Гэрт байдаг 5 · Тэтгэвэр/тэтгэмж 6 · Цэрэг 7 · Оюутан/сурагч 8</p> <p>Ажлын 6-аас 8-ийг сонгосон бол Нийгмийн байдал мөн Харъяалал хариулах шаардлагагүй</p>	<p>5. Нийгмийн байдал: - Ажилчин 1 - Албан хаагч 2 - Хувиараа хөдөлмөр эрхлэгч (бизнес) 3 - Малчин/тариачин 4 - Сэхээтэн 5</p> <p>6. Харъяалал: · Сонгуульт буюу тангараг өргөсөн төрийн а/х 1 · Төсвийн бусад байгууллага 2 · Хувийн / холимог сектор 3 · Төрийн бус байгууллага 4</p>		
<p>7. Гэрлэлтийн байдал: - Гэрлэсэн - Баталгаатай 1 - Гэрлэсэн - Баталгаагүй 2 - Гэрлээгүй 3 - Тусдаа амьдардаг/салсан 4 - Бэлэвсэн 5</p>	<p>8. Өрхийн ам бүлийн тоо:</p> <p>9. Өрхийн хэдэн гишүүн ажил эрхэлдэг вэ?:</p>	<p>10. Өрхийн орлого (татвар, НДШ төлөхөөс өмнө):</p> <table border="1" data-bbox="844 967 1188 1119"> <tr> <td data-bbox="844 967 1013 1119">Сарын байдлаар:</td> <td data-bbox="1020 967 1188 1119">Жилийн байдлаар:</td> </tr> </table>	Сарын байдлаар:	Жилийн байдлаар:
Сарын байдлаар:	Жилийн байдлаар:			
<p>11. Хаяг: Хот\Аймаг</p> <p>12. Утас:</p> <p>13. Ярилцлага авсан ажилтан</p>	<p>Дүүрэг/Сум</p>	<p>Хороолбаг</p>		

Судалгаанд оролцсон Танд баярлалаа!

